

ХУРДАН МОРИНЫ ХАВРЫН УРАЛДААН БА ХҮҮХДИЙН ЭРХ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН



unicef
НҮБ-ын Хүүхдийн сан



ӨМНӨХ ҮГ



Монгол Улсад 560 гаруй хууль хүчин төгөлдөр үйлчилж байгаагаас 80 орчимд нь хүүхэд, хүүхдийн эрхтэй холбоотой заалт тусгагдсан байна. Гэвч энэ нь хурдан морь унаач хүүхдийн эрхийг хамгаалах эрх зүйн орчныг хангалттай бүрдүүлж чадахгүй байна.

Олон улсын болон үндэсний хууль тогтоомжоор хүүхэд бол эрх зүйн бие даасан субъект мөн хэмээн нэгэнт хүлээн зөвшөөрсөн. Монгол Улс нь хүүхдийн эрхийг хамгаалах тухай НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай 1989 оны Конвенцид 1990 онд, ОУХБ-ын Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах тухай (1999) 182 дугаар Конвенцид 2001 онд, Насны доод хязгаарын тухай (1973) 138 дугаар Конвенцид 2002 онд тус тус нэгдэн орсон ч түүгээр хүлээсэн үүргээ хангалттай биелүүлж хэрэгжүүлж чадахгүй байгаа нь хаврын хурдан морины уралдаан дахь унаач хүүхдийн эрхийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлээгүй, тэдний эрх зөрчигдсөөр байгааг нотолж байна.

Энэхүү судалгааны ажлын зорилго нь хаврын уралдаанд унаач хүүхдийн эрхийн асуудлыг хууль, эрх зүйн хүрээнд хамгаалах зорилгоор тодорхой баримт, факттайгаар шинжлэх ухааны үндэслэлтэй гаргаж ирэхэд оршино.

Дээрх зорилготой холбоотойгоор 2011 оноос хойш судалгаа хийгдсэн бөгөөд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэгт заасны дагуу Хүний эрхийн Үндэсний комиссоос аймаг, сум, багийн засаг дарга нарт, Монголын Морин спорт уяачдын холбоонд болон Ерөнхий сайдад унаач хүүхдийн эрхийг хамгаалах чиг үүргийнх нь хүрээнд тус тус зөвлөмж хүргүүлэн ажилласан болно.

Энэхүү судалгааны ажил нь хаврын хурдан морины уралдаанд гарч буй хүндрэлүүдийг хууль санаачлагчид болон хууль тогтоогчдын анхааралд хүргэж хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх, хүйтний улиралд хүүхдэд эрүүл мэнд, бие бялдар, оюун санаа, боловсролын хувьд ямар нөлөөтэй болохыг, хаврын уралдаан нь монголын уламжлалт төрт ёсны өв соёлын нэгээхэн хэсэг мөн эсэхийг тодорхойлж тухайн асуудлаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэхэд ихээхэн үр дүнтэй ажил болжээ.

Ж.БЯМБАДОРЖ

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДАРГА



АГУУЛГА

НЭГ. УДИРТГАЛ	5
1.1 Судалгааны ажлын үндэслэл, шаардлага	5
1.2 Судалгааны зорилго, зорилт	7
1.3 Судалгааны баг	7
1.4 Судалгааны арга, арга зүй	8
ХОЁР. СУДАЛГААНЫ АЖЛЫН ХУРААНГУЙ	10
ГУРАВ. СУДАЛГААНЫ ҮР ДҮН	14
3.1 Хурдан морины уралдаанч хүүхдийн эрх, эрх зүйн байдал	14
1. Хурдан морины уралдаанч хүүхдийн эрхийг хамгаалах үндэсний хууль тогтоомж, дүрэм, журам	14
2. Хүүхдийн эрхийг хамгаалах олон улсын стандартууд	16
3.2 Хурдан морины уралдаанч хүүхдийн эрүүл мэндийн эрсдлийн асуудал	17
1. Эрүүл мэндийн эрсдлийг бий болгож байгаа хүчин зүйлүүд	17
2. Хурдан морины уралдаанч хүүхдэд учирч болзошгүй эрүүл мэндийн эрсдэлүүд	20
3.3 Хаврын хурдан морины уралдааны уралдаанч хүүхдийн сурч боловсрох эрхийн асуудал	24
1. Хурдан морины уралдаанч хүүхдийн хичээлийн хоцрогдол	24
2. Хурдан морины уралдаанч хүүхдийн сургууль завсардалт	25
3.4 Хурдан морины хаврын уралдаан нь монгол төрийн уламжлалт өв соёл мөн эсэх	26
3.5 Хаврын улиралд хурдан морь унах нь хүүхдийн аюултай хөдөлмөр мөн эсэх	27
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ	30
ТАВ. ЗӨВЛӨМЖ	33
ЗУРГАА. ХАВСРАЛТ	36
Хаврын хурдан морины уралдаан ба уралдаанч хүүхдийн эрх сэдэвт асуулгын судалгааны нэгтгэсэн тайлан.	36
Асуулгын судалгааны дүгнэлт	40

УИН.МН
СУДАЛГААНЫ САН



НЭГ. УДИРТГАЛ



1.1 СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА

Хурдан морины уралдаанч хүүхдийн эрхийн асуудал ойрын жилүүдэд хурцаар тавигдаж байна. Хүүхдүүдийн тухай унаж бэртсэн, зарим нь хорвоог орхисон¹ гээд сэтгэл эмзэглэм асуудлууд гарах боллоо. Хүүхдийн эрхийн тухай 1989 оны НҮБ-ын конвенцийн дагуу оролцогч улсууд хүүхдийн эрүүл мэндийг хохироох уламжлалт дадлыг халах зорилгоор үр нөлөөтэй бөгөөд зохистой бүх арга хэмжээг авна гэж олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө үүрэг хариуцлага хүлээснээ мартах ёсгүй билээ.

Монгол Улсын хувьд Үндсэн хуульдаа насанд хүрээгүй хүмүүсийн Үндсэн хуулийн эрх зүйн байдлын үндсийг тусгайлан хуульчлаагүй хэдий ч иргэдийн Үндсэн хуулийн эрх зүйн байдлыг бэхжүүлсэн Монгол Улсын Үндсэн хуулийн хоёрдугаар бүлэгт тулгуурлан тогтоодог. Монгол Улс 1990 онд НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай 1989 оны Конвенцийн оролцогч болсон бөгөөд холбогдох үндэсний хууль тогтоомжийг конвенцийн шаардлагад нийцүүлэх үүрэг хүлээсэн. Хүүхдийн эрхийн тухай конвенцид нэгдэн орсноор гишүүн улс өөрийн үндэсний хууль тогтоомжийг конвенцийн заалтад нийцүүлэн дахин нягтлан үзэх үүрэг хүлээх ба конвенцийн заалтыг биелүүлээгүй байх нь түүнийг олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хариуцлага хүлээх үндэслэл болдог.

Хүүхдийн эрхийн тухай конвенцид хүүхдийн эрх ашгийг нэн түрүүнд авч үзэхээр заасан ба үүнтэй холбоотой ямарваа нөхцөл байдал хүүхдийн амь нас, бие мах бодид аюул учруулахуйц байвал хүүхдийг түүнээс хамгаалах арга хэмжээг нэн тэргүүнд ямар нэг урьдчилсан нөхцөлгүйгээр авах ёстой.

Хурдан морийг Монгол Улсын Үндэсний их баяр наадмын тухай хууль тогтоомжоор 7-оос дээш насны хүүхэд унахаар заасан. Зуны дэлгэр цагт тохиодог Эрийн Гурван Наадмын нэг болох хурдан

¹ Энэхүү судалгааны хүрээнд Гэмтэл согог сэргээн засах үндэсний төвөөс гаргасан судалгаагаар сүүлийн 3 жилийн хугацаанд хурдан морьноос унаж бэртсэний улмаас 6 хүүхэд амь насаараа хохирсон гэх баримт байна. Энэ тоо нь зөвхөн ГССЗҮТ-д бүртгэгдсэн тоо юм.





морины уралдаан нь төрт ёсны түүхэн уламжлал билээ. Харин өдгөө хаврын улиралд уралдаанч хүүхдийн амь нас, эрүүл мэндэд эрсдэлтэй нөхцөлд бага насны хүүхдүүд морин уралдаанд оролцож байгаа нь олон улсын хүүхдийн эрхийн эрх зүйн үндсэн зарчмуудтай зөрчилдөж байна.

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын Конвенц, Зөвлөмжийн хэрэгжилтийн шинжээчдийн хорооноос Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах тухай 182-р конвенцийн хэрэгжилтийн талаар Монгол Улсын Засгийн газарт ирүүлсэн шууд хүсэлтэд уралдааны морь унах нь хүүхдийн аюулгүй байдал, эрүүл мэндэд аюултай буюу осолтой гэдгийг дурьдаад, Монгол Улсын Засгийн газрыг 18-аас доош насны хүүхдүүдийг морь уралдаанчаар ажиллуулахгүй байх тал дээр анхааран дорвитой арга хэмжээ авахыг хүссэн байна. Мөн тус Хороо дээр дурьдсан хамгаалалтын арга хэмжээний хэрэгжилтийг хангах тал дээр Засгийн газар тодорхой арга хэмжээ авч, хөдөлмөрийн байцаагч нараар гэнэтийн шалгалт хийлгэж, 18-аас доош насны хүүхдүүд тэдний эрүүл мэнд, амь насанд аюултай нөхцөлд морь уралдаан хийхийг нь хязгаарлаж, хамгаалан ажиллахыг уламжилжээ.

Энэхүү судалгааны хүрээнд:

Нэгдүгээрт: Хаврын уралдаанд оролцож буй хүүхдийн насны доод хязгаар 7 нас нь холбогдох олон улсын конвенцэд заасан хүүхдийн бие бялдар, оюун ухааны хувьд бүрэн боловсрох үеийнх нь настай нийцэж байгаа эсэх,

Хоёрдугаарт: Зайлшгүй эзэмшвэл зохих боловсролыг дүүргэх үеийн наснаас доош буюу ямар ч тохиолдолд 15-аас доош насны хүүхдийн сурч боловсрох эрх нь зөрчигдөх ёсгүй гэсэн зарчим хаврын уралдааны үед хөндөгдөж байгаа эсэх,

Гуравдугаарт: Хавар хурдан морь унах нь хүүхдийн аюултай хөдөлмөрийн хэлбэр мөн эсэхийг тодорхойлох шаардлагатай байна.

Хурдан морины уралдаанч хүүхдийн хүмүүжил, эрүүл мэнд, амь насны асуудал хурцаар яригдах болсон энэ үед уралдаанч хүүхдийн эрхийг хууль, эрх зүйн хүрээнд хангах арга замуудыг судалгааны үндсэн дээр тодорхойлох асуудал нэн тэргүүний хэрэгцээ шаардлага болон тулгамдаж байгаа тул Хаврын хурдан морины уралдаан ба хүүхдийн эрх сэдэвт судалгааны ажлыг гүйцэтгэлээ. Энэхүү судалгаа нь зөвхөн хаврын морин уралдааны тухай бөгөөд зуны уламжлалт уралдаанд ямар нэгэн нөлөө үзүүлэх ёсгүй гэдгийг онцлон тэмдэглэж байна.

СУДАЛГААНЫ САН





1.2 СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Энэхүү судалгааны ажил нь хаврын морин уралдаанд уралдаанч хүүхдийн эрхийн асуудлыг хууль, эрх зүйн хүрээнд хамгаалах зорилгоор тодорхой баримт, факттайгаар шинжлэх ухааны үндэслэлтэй гаргаж ирэхэд оршино. Үндэсний Их Баяр Наадмын тухай хуульд зааснаар зуны уралдаанд оролцогч хүүхдийн насны доод хязгаар нь 7 нас гэсэн асуудлыг хөндөхгүй болно.

Дээрх зорилгынхоо хүрээнд уралдаанч хүүхдийн эрхийн асуудал зуны уралдаанаас илүүтэй хаврын уралдааны үед илүү зөрчигдөж байгааг дараах зорилтуудыг дэвшүүлэн тодорхойлох болно. Үүнд:

1. Уралдаанч хүүхдийн эрх, эрх зүйн байдлыг тодорхойлох,
2. Хаврын хурдан морины уралдаан нь уралдаанч хүүхдийн эрүүл мэндийг эрсдэлд оруулж байгаа эсэх нөхцлийг тодорхойлох,
3. Хаврын уралдааны үед хүүхдийн сурч боловсрох эрх зөрчигдөж байгаа эсэхийг тодорхойлох,
4. Хаврын хурдан морины уралдаан нь монголын уламжлалт төрт ёсны өв соёл мөн эсэхийг тодорхойлох,
5. Хавар хурдан морь унах нь хүүхдийн аюултай хөдөлмөрийн хэлбэр мөн эсэхийг тодорхойлох.

Ийнхүү судалгааны эцсийн үр дүнд хаврын уралдааны хурдан морийг ямар наснаас дээш насны хүн унаж болохыг хууль санаачлагчид болон хууль тогтоогчдын анхааралд хүргэж хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх, хаврын уралдаан нь хүүхдэд эрүүл мэнд, бие бялдар, оюун санаа, боловсролын хувьд ямар нөлөөтэй болохыг, хаврын уралдаан нь монголын уламжлалт төрт ёсны өв соёлын нэг хэсэг мөн эсэхийг тодорхойлж тухайн асуудлаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх болно.

1.3 СУДАЛГААНЫ БАГ

Энэхүү судалгааг хууль зүйн доктор Б.Гүнбилэг ахлан Ц.Мөнгөнцацрал, Б.Мөнгөн-Аргамж нарын туслах судлаачдын бүрэлдэхүүнтэйгээр хийж гүйцэтгэлээ.

Судалгааны ажилд туслалцаа үзүүлж санал, зөвлөгөө өгсөн:

- М.Мөнхбат “Эрх зүйн судалгааны төв” ТББ-ын захирал, МУИС-ХЗС-ийн багш.
- С.Нямжав “Эрх зүйн судлагааны төв” ТББ-ын зөвлөх, Монгол Улсын гавьяат хуульч.
- С.Энхтүвшин, цаг уурч.
- Б.Даваажаргал, хүний их эмч.
- Т.Баясгалан, АУС-ийн Дотрын анагаахын тэнхмийн эрхлэгч.



- Б.Батпүрэв, АУС–ийн Дотрын анагаахын тэнхим, Бөөр судлалын профессорын багийн багш.
- Т.Ариунаа, АУС–ийн Дотрын анагаахын тэнхим, Бөөр судлалын профессорын багийн ахлагч, АУ–ны доктор (PhD), профессор.
- П.Баярсайхан, ГССҮТ–ийн Хавсарсан гэмтлийн тасгийн эмч, Хүний их эмч.
- Д.Мөнхсайхан, Сэтгэлзүйч.
- М.Адилбиш, Малын эмч

1.4 СУДАЛГААНЫ АРГА, АРГА ЗҮЙ

Энэхүү судалгааны багийн судалгааны арга зүйд гол баримтлах зарчим нь хаврын хурдан морины хүүхдийн эрхийн асуудлыг бодит судалгаагаар батлагдсан баримт мэдээллүүдэд тулгуурлан шинжлэх ухааны үүднээс асуудалд хандах явдал болно.

Судалгааны түүхчлэх, клиник, социологийн аргын хүрээнд энэхүү судалгаанд дараах үндсэн арга зүйг дангаар болон хавсран ашигласан болно. Үүнд:

Ажиглалт, нөхцөл байдлын судалгаа:

Хурдан морь ихээр уралддаг Сүхбаатар, Хэнтий, Булган, Төв аймаг, Орхон болон Улаанбаатар хотын Хан–Уул дүүргийн Өлзийт хороолол, Налайх дүүрэг зэрэг газруудад ажиглалт, бодит нөхцөл байдлын судалгааг асуулгын арга зүйтэй хавсран хийсэн болно.

Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага:

Хаврын хурдан морины уралдаанч хүүхдийн талаарх ерөнхий мэдээлэл, нийгэм сэтгэл зүй, эрүүл мэнд аюулгүй байдал болон боловсролын талаар мэдээлэл цуглуулж дүн шинжилгээ хийх зорилгоор ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагыг хурдан морины уралдаанч хүүхэд, багш, сургуулийн нийгмийн ажилтан, уяач, эцэг эх, асран хамгаалагчид болон жирийн иргэд зэрэг нийт 798 хүнийг хамран зохион байгууллаа. Асуулгыг судалгааны ажлын төлөвлөгөөний дагуу сонгогдсон газар буюу Улаанбаатар хотын Хан–Уул дүүргийн 19–р хороо, Өлзийт хороолол, Налайх дүүрэг, Төв аймгийн Зуунмод болон Зүүндэлгэр сум, Булган аймгийн Булган, Бугат, Хишиг–Өндөр сум, Орхон аймгийн Баян–Өндөр сум, Хэнтий аймгийн Чингис хот, Мөрөн сум болон Сүхбаатар аймгийн Баруун–Урт, Эрдэнэцагаан сум зэрэг газруудад хийж гүйцэтгэлээ.

Бүлгийн ярилцлагыг судалгааны хүрээнд хүрч ажилласан бага дунд сургуулиудын багш, нийгмийн ажилтан, Насан туршийн боловсролын төвийн багш сурган хүмүүжүүлэгчид болон уяачидтай зохион байгуулж, Хурдан морины уралдаанч хүүхдийн эрхийн талаар болон сургууль, эцэг эх, уяачдын зүгээс хүүхдийн эрхийн зөрчлийн эсрэг авч байгаа арга хэмжээний талаарх мэдээллийг баримтжуулсан болно.





Эрүүл мэндийн байгууллага дээр хийгдсэн клиник бодит судалгаа, бэртэл гэмтэлд дүн шинжилгээ хийх

Хурдан морины уралдаанч хүүхдийн эрүүл мэндийн судалгааг судалгааны ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу сонгогдсон газруудын харьяа өрхийн эмнэлэг, сумын эмнэлэг, аймгийн эрүүл мэндийн нэгдлийн яаралтай тусламжийн газар, мэс заслын болон хүүхдийн тасаг, ГССҮТ-ийн Хавсарсан гэмтлийн тасаг зэрэг байгууллагууд дээр хийсэн ба эдгээр байгууллагуудын эмч, эмнэлгийн ажилтнуудтай Хурдан морины уралдаанч хүүхдэд тохиолдох эрүүл мэндийн эрсдлийн талаар ярилцан, асуулгын анкет бөглүүлэн, холбогдох баримтыг цуглуулсан болно. Түүнчлэн ГССҮТ-ийн эмнэлгийн бүртгэлээс хурдан мориноос унасан хүүхэд эмчлүүлэхээр ирсэн эсэхийг лавлан, эмчлүүлэхээр ирсэн хүүхдүүдийн өвчний түүхэнд мэргэжлийн багтай хамтран дүн шинжилгээ хийсэн бөгөөд дийлэнх тохиолдож байгаа гэмтэлд дүн шинжилгээ хийх замаар хүйтний нөхцөл хүүхдийн эрүүл мэнд, бие бялдарт өөрчлөлт үзүүлж нөлөөлөх эсэхэд клиник талаас дүгнэлт гаргуулах оролдлого хийсэн болно.

Бичиг баримтад дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах:

Энэхүү судалгааны явцад хурдан морины хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр Монгол Улсад мөрдөгдөж байгаа хууль, хуульчилсан акт, олон улсын гэрээ конвенц зэрэг эрх зүйн баримт бичгүүдэд дүгнэлт хийсэн. Түүнчлэн улсын байгууллага, үндэсний архив болон судлаач эрдэмтдийн судалгаа, судалгааны тайлан, илтгэл, нийтлэл, статистик мэдээ болон эрүүл мэндийн байгууллагын бүртгэл, судалгаа зэргийг судлан дүгнэлт хийсэн болно. Үүнд тухайлбал НҮБ-ын дэмжлэгтэйгээр Хүүхдийн Төлөө Газраас 2010 онд хийгдсэн хурдан морины уралдаанч хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдлын асуудлаарх судалгааны тайланг онцлон үзэж зохих дүгнэлтийг хийсэн болно.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ХОЁР. СУДАЛГААНЫ АЖЛЫН ХУРААНГУЙ



2.1 ХУРДАН МОРИНЫ УРАЛДААНЧ ХҮҮХДИЙН ЭРХ, ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

Хурдан морины уралдаан нь монголын ард түмний төрт ёсны өв соёлын үнэт баяр цэнгээн байх уламжлалт хэв маягаасаа илүү өргөн цар хүрээтэй болж, зөвхөн зун биш өвөл, хавар уралдаан зохиогдох болсоноор хүүхэд унаж бэртэх, тэр бүү хэл амь насаа алдах хүртэл тохиолдол гарч байгаа тул олон улсын байгууллагууд болон монголын ард түмэн ч уралдаанч хүүхдийн эрхийн асуудалд анхаарал хандуулах болжээ.

1. Хурдан морины уралдаанч хүүхдийн эрхийг хамгаалах үндэсний хууль тогтоомж, дүрэм, журам

2015 оны 9 сарын 9-ний өдрийн байдлаар Монгол Улсад 569 хууль хүчин төгөлдөр үйлчилж байгаагаас 80 орчимд нь хүүхэд, хүүхдийн эрхтэй холбоотой зохицуулалт тусгагдсан байна. Монгол Улсын хувьд Үндсэн хуульдаа насанд хүрээгүй хүмүүсийн Үндсэн хуулийн эрх зүйн байдлын үндсийг тусгайлан хуульчлаагүй хэдий ч иргэдийн Үндсэн хуулийн эрх зүйн байдлыг бэхжүүлсэн Монгол Улсын Үндсэн хуулийн хоёрдугаар бүлгийн зүйл заалтад тулгуурлан тогтоодог.

2. Хурдан морины уралдаанч хүүхдийн эрхийг хамгаалах талаарх олон улсын эрх зүйн зохицуулалт

Олон улсын болон үндэсний хууль тогтоомжоор хүүхэд бол эрх зүйн бие даасан субъект мөн хэмээн нэгэнт хүлээн зөвшөөрөх болсон. Монгол Улс нь хүүхдийн эрхийг хамгаалах тухай НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай 1989 оны Конвенцид 1990 онд, ОУХБ-ын Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах тухай (1999) 182 дугаар Конвенцид 2001 онд, Насны доод хязгаарын тухай (1973) 138 дугаар Конвенцид 2002 онд тус тус нэгдэн орсон ч түүгээр хүлээсэн үүргээ хангалттай биелүүлж хэрэгжүүлж чадахгүй байгаа нь хаврын хурдан морины уралдаан дахь уралдаанч хүүхдийн эрхийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлээгүй, тэдний эрх зөрчигдсөөр байгаараар нотлогдож байна.





2.2 ХУРДАН МОРИНЫ УРАЛДААНЧ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭРСДЛИЙН АСУУДАЛ

1. Эрүүл мэндийн эрсдлийг бий болгож байгаа хүчин зүйлүүд

Хурдан морины уралдаанч хүүхдийн бэртэл, гэмтлийн бүртгэл мэдээлэлд дүн шинжилгээ хийж, холбогдох эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдтэй ярилцсаны үндсэн дээр хаврын хурдан морины уралдаанд оролцож буй хүүхдийн эрүүл мэндийн эрсдлийг бий болгож байгаа хүчин зүйлүүдийг дараах байдлаар тодорхойлж болохоор байна. Үүнд: Хурдан морины уралдаанч хүүхдийн нас, Цаг агаар, уур амьсгалын нөхцөл байдал, Адуу, Уралдааны зохион байгуулалт, Уяачдын туршлага, чадварын асуудал зэргийг нэрлэж байна.

2. Хурдан морины уралдаанч хүүхдэд учирч болзошгүй эрүүл мэндийн эрсдэлүүд

Эрүүл мэндийн байгууллага дээр хийгдсэн клиник бодит судалгаа болон бэртэл гэмтэлд хийгдсэн дүн шинжилгээгээр хурдан морины уралдаанч хүүхдэд Толгой болон мөчдийн гэмтэл, Ясны хугаралт, Хөлдөлт, осголт, Амьсгалын замын өвчин, Дотор эрхтэний доргилт, өвчлөлт, Нүдний эвэрлэг бүрхүүлийн гэмтэл зэрэг бэртэл гэмтэл авдаг байна.

2.3 ХАВРЫН ХУРДАН МОРИНЫ УРАЛДААНЫ УРАЛДААНЧ ХҮҮХДИЙН СУРЧ БОЛОВСРОХ ЭРХИЙН АСУУДАЛ

Хурдан морины хаврын уралдааны үеэр уралдаанч хүүхдүүд дор хаяж, 30 хүртэл хоногоор хичээлээс чөлөө авах, таслах байдал, эсхүл хичээлдээ явсан ч гэрийн даалгавараа хийхгүй байх нь их байдаг тул хоцорсон хичээлийг нөхөж заах, хоцрогдлыг арилгах арга хэмжээ авах нь сургууль болон багш нарын үүрэг хэдий ч багш нарын болон анги танхимын хүрэлцээ муу, цаг хугацааны асуудал зэргээс болоод боломжгүй байдаг, мөн давтлага хичээл хийлгэсэн ч үр дүн бага гардаг байна.

Хичээлээс хоцрогдож үеийн хүүхдүүдээс сурлагын дүнгээр мууд тооцогдох болсон хүүхдүүд хичээл ном сонирхохоо больж морь унаж амьдрах нь боломжтой, энэ чигээрээ байж болно гэсэн хийсвэр төсөөлөлтэй болдог байна. Асуулгын судалгаанд оролцсон Хурдан морины уралдаанч хүүхдүүдийн насны үзүүлэлтээс үзвэл дийлэнх буюу 64 хувь нь 13-аас доош настай байгаа нь хурдан морь унах хүүхдийн нас, бие бялдарын хөгжлөөс шалтгаалан 12, 13 наснаас хурдны морь унахаа больдог.

Хурдан морь унаж уралдах шалтгаанаар хичээлээс хоцрогдсоны улмаас сурах сонирхол идэвхгүй болсон хүүхдүүд тухайн уяач, эздийнхээ морь малны бусад ажлыг хийх, мал хариулах зэрэг ажлыг хийж амьдрахаас өөр замгүй болсноор сургуулиас завсардах нөхцлийг бүрдүүлдэг байна.



2.4 ХАВРЫН ХУРДАН МОРИНЫ УРАЛДААН НЬ МОНГОЛЫН ТӨРТ ЁСНЫ ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ МӨН ЭСЭХ

2010 оны 10 дугаар сард НҮБ-ын Боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллага (ЮНЕСКО)-ын Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн төлөөллийн Жагсаалтад “Монголын уламжлалт баяр болох Наадам” бүртгэгдсэн. Гэвч Хурдан морины уралдаан нь монголын ард түмний төрт ёсны өв соёлын үнэт баяр цэнгээн байх уламжлалт хэв маягаасаа илүү өргөн цар хүрээтэй болж, зөвхөн зун биш өвөл, хавар уралдаан зохиож, хүүхдийн амь нас, эрүүл мэнд, боловсролд сөргөөр нөлөөлөхүйц байдлаар бооцоотой гэх мэт хүүхдийн тэвчишгүй хүнд хөдөлмөрийн хэлбэрт шилжээд байна.

Үндэсний төв архивын сан хөмрөгт хадгалагдаж буй (1803–1920 оны) Наадмын баримтын нийт 381 цуглуулга дансыг шүүж үзэхэд тухайн оныхоо 5–8 дугаар сард даншиг наадмаа хийж байсан нь тодорхой харагдаж байна. Мөн Хан Хэнтий уулын аймгийн Галшар уулын хошууны дансыг шүүж үзэхэд мөн тухайн оны 5–8 дугаар сард даншиг наадмаа хийж байжээ.

Монголчууд 20–р зууны төгсгөлөөр өвлийг өнгөрөөж хаврыг угтаж, урт уяа сойлго хийж, холхон зайд морь уралдуулах заншил, арга барилд шинэчлэлт хийж эхэлсэн хэмээн үздэг. Хурдан морины хаврын уралдаан нь зарим газарт ахуйн хүрээнд зохион байгуулагдаж байсан ба 1995 оноос олныг хамарсан байдлаар зохион байгуулагдаж, 2004 оноос албан ёсны болгож Засгийн газрын тогтоолоор зохион байгуулагдах болжээ.

Үүнээс үзвэл хурдан морины уралдаан нь төрт ёсны түүхэн уламжлал, өв соёл мөн боловч өвөл, хаврын улиралд зохион байгуулах нь төрт ёсны түүхэн уламжлал, өв соёл хэмээн үзэх бодит үндэслэлгүй байна. Харин ахуйн чанартай багахан уралдаанууд зохиогдож байсныг судалгааны явцад өндөр настнууд нотолсон болно.

Иймд хаврын уралдааныг төрт ёсны болон ахуйн чанартай гэж ангилж үзэн ялгамжтайгаар зохицуулах нь зүйтэй байна.

2.5 ХАВРЫН УЛИРАЛД ХУРДАН МОРЬ УНАХ НЬ ХҮҮХДИЙН АЮУЛТАЙ ХӨДӨЛМӨР МӨН ЭСЭХ

Хаврын хурдан морины уралдаан маш олон эрсдэлтэй нөхцөлд болж, энэ эрсдлийг үл харгалзан хүүхдээр хурдан морь унуулж байгаа нь хүүхдийг аюултай хөдөлмөр эрхлүүлж байна гэж үзэж болохыг энэхүү судалгааны баримтууд нотолж байна. Хурдан морины уралдаанч хүүхдийн амь нас, эрүүл мэндэд шууд эрсдэл бий болгож байгаа болон сурч боловсрох эрхэд сөргөөр нөлөөлж байгаа байдал зэрэг нь хаврын хурдан морины уралдаанд оролцож байгаа уралдаанч хүүхдийн хөдөлмөр нь ОУХБ-ын “Хүүхдийн аюултай хөдөлмөр” гэсэн ойлголтод шууд хамаарч байна.





2.6. ДҮГНЭЛТ

Нэг. Манай Улс хүүхдийн эрхийг хамгаалах олон улсын гэрээ конвенцид нэгдэн орсон боловч үүний дагуу дотоодын хууль тогтоомжоо боловсронгуй болгох үйл ажиллагаа төдийлөн бүрэн хангагдаагүй байна. Өөрөөр хэлбэл хурдан морины уралдаанч хүүхдийн эрхийг хамгаалах эрх зүйн тогтолцоо манай улсад одоогоор байхгүй байна.

Хурдан морины уралдаанч хүүхэд эрүүл мэндээрээ хохироход уяач, эцэг эх нар хоорондоо тохиролцоод эмчилгээний зардлыг төлөх төдийгөөр өнгөрөх, амь насаа алдсан тохиолдолд хариуцлага хүлээх болон хүлээлгэх эзэнгүй, хэн нэгэн буруутай этгээдийг тогтоож хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчин байхгүй байгаа нь хүүхдийн эрхийн ноцтой зөрчил болж байна.

Хоёр. Хаврын хурдан морины уралдаан нь зохион байгуулагдах үеийн цаг агаарын байдал, уралдааны зам болон зохион байгуулалт, уралдаанч хүүхдийн насны байдал нь хурдан морины уралдаанч хүүхдийн эрүүл мэндийн эрсдлийг улам бүр нэмэгдүүлж, хүнд тэвчишгүй хөдөлмөр эрхлэлтэд тооцогдох нөхцлийг бий болгож байна.

Гурав. Хурдан морь унадаг хүүхдүүдийн дийлэнх нь хурдан морийг сонирхолоороо унадаг хэмээн хариулж байгаа хэдий ч түүний ар гэр, амьдралын түвшин, гэр бүлийн анхаарал халамж, эцэг эхийн боломж бололцоо зэргээс ихээхэн хамаарч энэхүү замыг сонгож байгаа нь тодорхой байна.

Дөрөв. Өвөл, хаврын хурдан морины уралдаанд хүүхдийг хичээл, сургуулиас нь чөлөө авах, таслуулах зэргээр хөндийрүүлснээр хоцрогдож, сурлагын түвшин буурдаг байна. Цаашилбал хичээл сургуульд дургүй болж сургуулиас гарах, завсардах зэрэг сөрөг асуудлуудыг багагүй дагуулсаар байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



ГУРАВ. СУДАЛГААНЫ ҮР ДҮН



3.1 ХУРДАН МОРИНЫ УРАЛДААНЧ ХҮҮХДИЙН ЭРХ, ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

Монголчууд 20–р зууны төгсгөлөөр өвлийг өнгөрөөж хаврыг угтаж, урт уяа сойлго хийж, холхон зайд морь уралдуулах заншил, арга барилд шинэчлэлт хийж эхэлжээ.

Хэдийгээр хурдан морийг уяж, сойх арга шинэчлэгдэж байгаа ч хурдан морины уралдааны гол субъект болох уралдаанч хүүхдийн эрхийн асуудал болон аюулгүй байдлыг орхигдуулж, өвөл, хаврын хасах градуст хурдан морь унуулж, амь нас, эрүүл мэндэд аюултай ажил хөдөлмөр эрхлүүлж байна. Хурдан морины уралдаан нь монголын ард түмний төрт ёсны өв соёлын үнэт баяр цэнгээн байх уламжлалт хэв маягаасаа илүү өргөн цар хүрээтэй болж, зөвхөн зун биш өвөл, хавар уралдаан зохиогдох болсноор хүүхэд унаж бэртэх, тэр бүү хэл амь насаа алдах хүртэл тохиолдол гарч байгаа тул олон улсын байгууллагууд болон монголын ард түмэн ч уралдаанч хүүхдийн эрхийн асуудалд анхаарал хандуулах болжээ.

1. Хурдан морины уралдаанч хүүхдийн эрхийг хамгаалах үндэсний хууль тогтоомж, дүрэм, журам

2015 оны 9 сарын 9–ний өдрийн байдлаар Монгол Улсад 569 хууль хүчин төгөлдөр үйлчилж байгаагаас 80 орчимд нь хүүхэд, хүүхдийн эрхтэй холбоотой зохицуулалт тусгагдсан байна. Монгол Улсын хувьд Үндсэн хуульдаа насанд хүрээгүй хүмүүсийн Үндсэн хуулийн эрх зүйн байдлын үндсийг тусгайлан хуульчлаагүй хэдий ч иргэдийн Үндсэн хуулийн эрх зүйн байдлыг бэхжүүлсэн Монгол Улсын Үндсэн хуулийн хоёрдугаар бүлгийн зүйл заалтад тулгуурлан тогтоодог.

1996 онд Монгол Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль батлагдсан бөгөөд тус хуулийн 7 дугаар зүйлд зааснаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хүүхдийг албадан ажиллуулах, ёс суртахуун, эрүүл мэнд, амь насанд нь аюул учруулах хөдөлмөр эрхлүүлэхийг хориглосон. Мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “...Ашиг хонжоо олох, хүүхдийн эрүүл мэнд, амь насанд аюул учруулах тоглоом наадамд оролцуулахыг хориглоно” гэж заасан байна.





Үндэсний их баяр наадмын тухай хуульд Хурдан морины уралдаанч хүүхдийн нас 7-оос дээш байх тухай (8 дугаар зүйлийн 2-т) заасан ба энэхүү заалт нь зөвхөн Наадмын өдрүүдээр зохион байгуулагддаг хурдан морины уралдаанд хамааралтай. Үндэсний их баяр наадмын хурдан морины уралдааны шинэчлэгдэн батлагдсан дүрэмд билгийн тооллоор намрын сүүл сараас хаврын тэргүүн сарын шинийн 3-ныг хүртэлх хугацаанд энэ нь ойролцоогоор аргын тооллоор 10 дугаар сарын 15-аас 2 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаа\ аймаг, сумын хэмжээнд хурдан морины уралдаан зохион байгуулахгүй байхаар заасан байдаг.

Биеийн тамир спортын тухай (2003) хуулийн 3.1.5-д заасан заалтаар Хурдан морины уралдаанч хүүхдийг тамирчин¹ гэсэн ойлголтод хамруулж болно гэж үзэх тал байгаа боловч эрт дээр үеэсээ Монгол үндэстний уламжлан наадаж ирсэн эрийн гурван наадмыг спортын төрөл мөн эсэх асуудал дээр судлаачид бас өөр өөр байр суурьтай байдаг учир Хурдан морины уралдаанч хүүхдийг тамирчин гэж үзэх асуудал ч эргэлзээтэй байдаг.

Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам (НХХЯ), Улсын мэргэжлийн хяналтын газар (УМХГ)-ын хамтын ажиллагааны хүрээнд “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-ыг боловсруулж, Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдын 2008 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 107 тоот тушаалаар баталсан ба энэхүү жагсаалтад хурдан морины уралдааны асуудал хөндөгдөөгүй байна.

Засгийн газрын 2011 оны 303 дугаар тогтоолын хавсралтаар Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах үндэсний хөтөлбөрийг боловсруулан батлахдаа хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааны чиглэлээр “Хурдан морины уралдаанч хүүхдийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлыг хангах үндэсний стандартыг боловсруулан баталгаажуулж мөрдүүлэх”²-ээр зааж хүүхдийн хурдны морь унах, уралдах асуудлыг “хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр” гэх хөтөлбөрт багтаан үзсэн байна. Энэ хөтөлбөрт үндэслэн Үндэсний морин уралдааны морь уралдаанч хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлага MNS 6264:2011 стандартыг батлан хэрэгжүүлж байна.

Хөтөлбөрийн 3.7.5-т “Хурдан морины уралдаанч болон мал маллаж байгаа хүүхдэд учруулж болзошгүй аюул, эрсдэлтэй үйлдлийг судлан тогтоох, түүнийг “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглох ажлын байрны жагсаалт”-д тусган хориглох ажлыг зохион байгуулах”-аар зааснаас гадна Хурдан морины уралдаанч хүүхдийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлыг хангах асуудлыг тусгайлан авч үзсэн төдийгүй ийм төрлийн хөдөлмөр эрхлүүлсний улмаас хүүхдийн амь нас, эрүүл мэнд нь хохирсон бол гэм буруутай этгээдээс нөхөн төлбөр гаргуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх зорилт тавьсан байна.

¹ Биеийн тамир, спортын тухай хууль. 2003 он. § 3.1.5. “тамирчин” гэж спортоор системтэй хичээллэж, тэмцээнд оролцдог этгээдийг хэлэх

² Засгийн газрын 2011 оны 303 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах үндэсний хөтөлбөрийн 3.1.4.



Үндэсний их баяр наадмын хурдан морины уралдааны дүрэм, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 02 дугаар тогтоол, Монгол Улсын Шадар сайдын 2005 оны 05 тоот тушаал, Монголын нийт уяачид, морин спорт сонирхогчдод хандсан Уриалгад дэвшүүлсэн хурдан морины уралдаанч хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах зорилтуудыг хэрэгжүүлэх хүрээнд “Хурдан морины уралдаанч хүүхдийн эсэн мэнд амьдрах эрх, аюулгүй байдлыг хамгаалах хамтын ажиллагааны санамж бичиг” тус тус дагаж мөрдөж байна.

Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2011 оны 28 дугаар тогтоолоор Үндэсний морин уралдааны морины уралдаанч хүүхдийн хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлага буюу MNS 6264:2011 заавал мөрдөх стандарт баталж, Хурдан морины уралдаанч хүүхдийн уралдаан болон бэлтгэл сургуулилтын үед өмсөх малгай, нүдний шил, цээживч, өвдгөвч, тохойвч, гутал, эмээл, хазаар, ташуурт тавих шаардлагыг тогтоосон байна.

2. Хүүхдийн эрхийг хамгаалах олон улсын стандартууд

Женевийн тунхаглал (1924), Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1959) зэрэг олон улсын эрх зүйн хууль тогтоомжоор хүүхэд бол эрх зүйн бие даасан субъект мөн хэмээн үзэж, хүүхдийн эрхийг эрхэмлэн хүндэлж, чандлан хамгаалах асуудлыг тунхагласан. Монгол Улс 1990 онд НҮБ-ийн Хүүхдийн эрхийн тухай 1989 оны Конвенцийн оролцогч болсон бөгөөд холбогдох үндэсний хууль тогтоомжийг тус конвенцийн заалтад нийцүүлэн шинэчлэн дагаж мөрдөх, конвенцийн заалтыг чандлан биелүүлэх үүрэг хариуцлагыг олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн.

Монгол улс нь ОУХБ-ын Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах тухай (1999) 182 дугаар Конвенцид 2001 онд, Насны доод хязгаарын тухай (1973) 138 дугаар Конвенцид 2002 онд тус тус нэгдэн орсон байдаг.

ОУХБ-ын Конвенц, зөвлөмжүүдийн хэрэгжилтийг хянах шинжээчдийн хорооноос 182 дугаар Конвенцийн хэрэгжилтийн талаар Монголын Засгийн газарт ирүүлсэн шууд хүсэлтийн Заалт (г) (Аюултай ажил. Морь уралдаанч.)-д уралдааны морь унах нь утгаараа өөрөө аюултай буюу осолтой нөхцөлд тооцогдох ба хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд гэмтэл учруулах магадлалтай тул 18 наснаас доош насны хүүхдийг морь унахыг үргэлжлүүлэн зөвшөөрч байгаад эмзэглэн санаа зовж байгаагаа илэрхийлээд Засгийн Газраас нэн даруй арга хэмжээ авахыг хүссэн байна.

Хурдан морины уралдаанч хүүхдийн эрхийн хүрээнд нэн тулгамдсан асуудал бол хүүхдийн насны асуудал юм. Хүүхдийн насны асуудлыг оновчтой шийдвэрлэхийн тулд аль өнцгөөс энэ асуудалд хандахаас хамаарна. Өөрөөр хэлбэл, уралдаанч хүүхдийн насны асуудлыг тодорхойлохдоо нэг талаас хүүхдийн эрхийн асуудлыг хөндөх ёстой бол, нөгөө талаас соёлын өв, уламжлалын асуудлыг авч үзэх шаардлагатай байдаг. Харин дээрх хоёр асуудлыг нэмэх, хасах туйлаар биш харин энэ хоёр асуудлын уулзвар дээр хүүхдийн аюулгүй байдлыг хангах талаас авч үзэх зохимжтой хэмээн үзэж байна.





3.2 ХУРДАН МОРИНЫ УРАЛДААНЧ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭРСДЛИЙН АСУУДАЛ

1. Эрүүл мэндийн эрсдлийг бий болгож байгаа хүчин зүйлүүд

Морин уралдааны болон уналгын бүхий л хэлбэрүүд нь гэмтэл бэртлийн өндөр эрсдлийг дагуулж байдаг. Үүнд хурдан морь уях ажил болох тар, үсэргээ, сунгаанаас эхлээд уралдаан, амралт, зугаалга болон мал маллахтай холбоотой уналга зэрэг бүхий л төрлүүд хамаарна. Адууны дээд хурдаар, байгалийн замд уралддаг уралдаанч хүүхдийн эрүүл мэнд, амь нас асар өндөр эрсдлийн дунд байдаг болох нь доорх судалгаанаас харагдаж байна.

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн бүртгэлээс үзэхэд 2012 онд 326 хүүхэд мориноос унаж гэмтэл авсны улмаас эмнэлгийн яаралтай тусламж авч байсан бол 2013 онд 308, 2014 онд 307 хүүхэд эмнэлгийн яаралтай тусламж авч байсан байна. Хэвтэн эмчлүүлсэн хүүхдийн тоо 2012 онд 181, 2013 онд 219, 2014 онд 205, нас барсан хүүхдийн тоо дээрх гурван жил тус бүрт 2 байжээ.

Бэртэл, гэмтлийн бүртгэл мэдээлэлд дүн шинжилгээ хийж, холбогдох эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдтэй ярилцсаны үндсэн дээр хаврын хурдан морины уралдаанд оролцож буй хүүхдийн эрүүл мэндийн эрсдлийг бий болгож байгаа хүчин зүйлүүдийг дараах байдлаар тодорхойлж болохоор байна. Үүнд:

Нас. Манай оронд хурдан морь унах хүүхдүүдийн тоо жилээс жилд нэмэгдсээр байна. 2015 оны байдлаар жилд давхардсан тоогоор 40 орчим мянган хүүхэд хурдан морь унадаг гэсэн тооцоо байдаг. Хурдан морины уралдаанч хүүхдүүдийн ихэнх нь бага насны буюу 7–10 насны хүүхдүүд байгаа нь хүүхдүүд өөрийгөө эрсдлээс хамгаалах, гэнэтийн аюултай нөхцөл байдлыг даван туулах чадвар сул, бие бялдар, оюун ухааны хувьд төлөвших болоогүй байдагтай шууд холбоотой хэмээн үзэж болохоор байна. Уралдаанч хүүхдийн нас бага учир тулгарах гэнэтийн нөхцөл байдал, эрсдлийг даван туулах чадвар сул, мөн уралдаанч хүүхэд морьтойгоо ижил дасал болж зан зангаа авалцах боломж бага. Төв сууринд амьдарч, сурч байгаа хүүхдүүд шууд л хурдан морины нуруун дээр гарах шаардлага бий болж байгаа нь тэдэнд дадлагажих хугацааг маш бага олгож байна. Мөн уралдааны өмнөхөн уралдаанч хүүхдээ морио сайн мэдэхгүй, морьтойгоо дасаагүй хөнгөн хүүхдээр солих хандлага их байдаг нь эрүүл мэндийн эрсдлийн гол хүчин зүйл нь болдог байна.

Цаг агаар, уур амьсгалын нөхцөл байдал. Хаврын морин уралдаан нь билгийн тоолоор хаврын эхэн сарын шинийн 1–ний өдөр /энэ нь аргын тооллын 2 дугаар сарын дундуур тохиолддог/ зохион байгуулагдаж эхлэдэг. Монгол орон дэлхийн хамгийн хүйтэн орны нэгд зүй ёсоор тооцогддогийн хувьд 2 дугаар сарын цаг агаар дунджаар –10–аас –20 хэмийн хооронд хэлбэлзэнэ. Иймд хүйтэн цаг ууртай холбоотойгоор уралдаанч хүүхдэд учрах эрүүл мэндийн асуудлыг авч үзэх шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Уралдаанч хүүхдийн гар хөлийн хуруу, чих хамар хайрагдаж хөлдөх эрсдэл өндөр байдаг. Эдгээр эрхтнүүд нь захын эрхтнүүд учир дулааныг ялгаруулах томоохон булчин байдаггүй тул



амархан хөлддөг. Хүйтэн цаг уурт хүний биеийн ерөнхий дулаан дотор эрхтнүүдийг дулаацуулахад зориулагддаг учир захын эрхтнүүдэд очих цусны урсгал багасдагтай холбоотой эдгээр эрхтэнүүд богино хугацаанд хөлдөх эрсдэлд ордог байна. Бээлий, малгай, дулаан хуурай гутал зэргийг өмсүүлэх нь хөлдөлт үүсэх хугацааг уртасган, хамгаалалт болох боловч хэт хүйтэн, жавар салхитай үед хол замд уралдах нь хөлдөлт үүсэх эрсдлийг маш хурдан бий болгоно. Ямар нөхцөлд ямар хугацаанд хөлдөлт үүсч болохыг дараах графикаар харуулсан болно.

САЛХИНЫ ХҮЙТНИЙ ХЭМИЙН ГРАФИК (Цельс)

		температур (°C)									
		5	0	-5	-10	-15	-20	-25	-30	-35	-40
салхины хурд (км/ц)	10	3	-3	-9	-15	-21	-27	-33	-39	-45	-51
	20	1	-5	-12	-18	-24	-31	-37	-43	-49	-56
	30	0	-7	-13	-20	-26	-33	-39	-46	-52	-59
	40	-1	-7	-14	-21	-27	-34	-41	-48	-54	-61
	50	-2	-8	-15	-22	-29	-35	-42	-49	-56	-63
	60	-2	-9	-16	-23	-30	-37	-43	-50	-57	-64
	70	-2	-9	-16	-23	-30	-37	-44	-51	-59	-66
	80	-3	-10	-17	-24	-31	-38	-45	-52	-60	-67
	90	-3	-10	-17	-25	-32	-39	-46	-53	-61	-68
	100	-3	-11	-18	-25	-32	-40	-47	-54	-61	-69

салхины хэм (°C) = $13.12 + 0.6215T - 11.37(V^{0.16}) + 0.3965T(V^{0.16})$ T = температур (°C)

хөлдөлтийн хугацаа ■ 30 минут ■ 10 минут ■ 5 минут V = салхины хурд (км/ц)

Эх сурвалж: АНУ, Канадын цаг уурын алба

Энэхүү графикаас харахад -15 хэмтэй, салхины хурд 10 км/цаг байх үед агаарын хэм -21 хэмийн хүйтэнтэй тэнцэх нөлөөллийг үүсгэдэг бөгөөд хөлдөлт 30 минутанд үүсэх боломжтой байна.

Хаврын улиралд зохиогдож байгаа уралдаануудад дээд гурван нас ихэвчлэн уралддаг ба уралдаанч хүүхэд өдөрт гурван насны морь унаж уралдаж байна. Хаврын уралдаанд их нас дунджаар 18–20 км, азарга соёолон 16–18 км замд уралдаж байгаа бөгөөд гараа хүртэлх болон эргээд уралдах зайг тооцоолбол уралдаанч хүүхэд -10-аас -20 хэмийн хүйтэнд 100–112 км замыг туулж байна.

Хаврын уралдааны үед цасыг цэвэрлэн зам гаргахдаа хэт нарийхан зам гаргадаг учир морьд тарж уралдах боломжгүй байдаг. Ингэснээр мориноос унасан хүүхэд бусад морьдод гишгэгдэн гэмтэх, бусад морьд унаж ойчсон морь болон хүүхдэд тээглэж унах магадлал өсдөг. Түүнчлэн, уралдааны зам хол, зориулалтын бус, стандарт байхгүй, жалга судаг, гол горхи, сул элс, хайрга чулуу, намаг шавар, уул толгод ой мод дамжин уралддаг зэрэг нь хаврын уралдааны үед хөлдүү газрын асуудалтай нэгдсэнээр эрүүл мэндийн эрсдлийг улам хурцатгаж байна.





Ийнхүү хаврын хурдан морины уралдаан нь хүйтэн цаг агаарын нөхцөлд зохион байгуулагддаг тул уралдаанч хүүхдийн эрүүл мэндэд өндөр эрсдэл бий болгодог гэсэн дүгнэлтэд хүрч болохоор байна.

Адуу. Адуу нь өөрөө адгуус амьтны хувьд уралдаанч хүүхэд бэртэл гэмтэл авах нэг хүчин зүйл болдог. Адуутай холбоотой гэмтэл бэртэл дэлхий нийтэд маш түгээмэл бөгөөд авто ослын адил хамгийн элбэг тохиолддог ослуудын нэгд тооцогддог. Энэ нь адуутай холбогдож байгаа хэнд ч тохиолдож болох бөгөөд үүний 40–60 хувийг уралдаанчийн аюулгүй байдлыг зөв хангах болон морийг зөв сургаснаар бууруулах боломжтой гэж үздэг байна.

Адуутай холбоотой осол гэмтлийн гол таван шалтгааныг дэлхий нийтэд дараах байдлаар авч үздэг байна. Үүнд:

- Уралдаанч болон морийг сайтар сургаж дадлагуулаагүйгээс
- Уралдаанч адууныхаа зан авир болон сэтгэхүйн талаар ойлголт мэдлэг муу байснаас
- Уралдаанчийн хувцас хэрэгслэл болон морины эмээл хэрэгслэл тохиромжгүй байснаас
- Уралдаанч анхаарлаа сулруулснаас
- Тулгарч болзошгүй нөхцөл байдлыг тооцоолон бэлтгэлийг хангаагүйгээс зэрэг шалтгаан ордог байна.

Дээр дурдсанчлан хаврын уралдаанд хүүхдүүд эрсдлийг бүрэн тооцох чадваргүй, өөрийгөө эрсдлээс хамгаалах болон гэнэтийн аюултай нөхцөл байдлыг даван туулах чадвар сул, бие бялдар, оюун ухааны хувьд төлөвшөөгүй бага насандаа уралдаанд оролцож байгаа нь эрүүл мэндийг эрсдлийг бүрдүүлж буй хүчин зүйл болж байна.

Уралдааны зохион байгуулалт. Уралдааны зохион байгуулалт сул, харилцан адилгүй байдаг нь уралдааны гараа болон уралдах явцад хүүхэд унаж бэртэн эрүүл мэндээр хохирох нөхцлийг бүрдүүлдэг. Гарааны төхөөрөмжийн нэгдсэн стандартгүй, аймаг сум тус бүр янз бүрийн байдлаар хийсэн гарааны төхөөрөмжтэй, төхөөрөмжийг ажиллуулах хүмүүсийг сайн дадлагуулдаггүй зэрэг нь гараан дээр хүүхэд мориноос унах эрсдлийг нэмэгдүүлдэг. Түүнчлэн, уралдааны зам зориулалтын бус, стандарт байхгүй, уралдааны зам хөлдөлттэй зэрэг нь уралдааны явцад морь халтирах, хүүхэд унах эрсдлийг бий болгож байна. Уралдааныг олон тооны машин дагалдах явдал нь маш их тоос босгож, үзэгдэх орчин хязгаарлагдан уралдаанч хүүхэд замын нөхцөл байдлаар харж морио удирдах боломжгүй болох, амьсгалын замаар үүсэх өвчинд нэрвэгдэх суурийг тавих, мөн тэрчилэн уралдаанч хүүхэд авто осолд орох өндөр магадлалыг бий болгож байна. Жишээ нь: Соёолонгийн уралдааны үед энэ байдал бүр дорддог.

Дээр дурдсан байдал нь асуулгад оролцсон хүүхдүүдийн хариултаар мөн батлагдаж байна. Үүнд асуулгад оролцсон хүүхдүүдийн 71.6 хувь нь бэртэл гэмтэл хамгийн их гардаг улирлаар хаврын улирлыг, хурдан морь унах хамгийн муухай хэцүү улирлаар 81.6 хувь нь өвөл цастайд гэж хариулсанаас үзэхэд илт байна.



Хаврын уралдааны үед болон уралдааны бэлтгэлийн үед хамгийн их бэртэл гэмтэл гардаг шалтгааныг дурьдана уу? гэсэн олон сонголттой асуултанд хамгийн олон сонгогдсон хариулт нь уралдааны зам гэж 158, дагаж байгаа машины тоос гэж 129, уралдааны үед хүүхдүүд бие биенийгээ гэмтээдэг гэж 106, бороо, цас, салхи, цаг агаар гэж 104 хүүхэд хариулсан байна.

Уяачдын туршлага, чадварын асуудал. Уяачдын туршлага харилцан адилгүй байдгаас уралдаанч хүүхдэд өгч буй аюулгүй байдлын зааварчилгаа хангалттай бус байна. Тухайлбал эмээл хэрэгслэлийг зөв, аюулгүй байдлаар хэрэглэх, бат бөх, найдвартай эмээл хэрэгслэл хэрэглэх тал дээр учир дутагдалтай, аюулгүй байдлыг хангасан хувцас хэрэгслэлийн хэрэглээ сул, чанар муу зэрэг асуудлууд байсаар байна.

Ийнхүү дээр дурьдсанаас үзвэл хурдан морины уралдаанч хүүхдийн эрүүл мэндийн эрсдлийг бий болгож буй хүчин зүйлүүдийн сөрөг нөлөөлөл нь хаврын уралдааны үед улам нэмэгддэг болох нь харагдаж байна. Уралдаанч хүүхдүүд уралдааны бэлтгэл, сунгаанаас эхлээд уралдааны барианд орох хүртэлх хугацаанд амь нас, бие бялдар, оюун ухаан, самбаа, уяачийн туршлага, өөрийн болон бусад уяачийн уяж сойж уралдуулж байгаа морь, уралдааны зам, зохион байгуулалт зэрэг маш олон өндөр эрсдэл бүхий хүчин зүйлийг даван туулдаг болох нь харагдаж байна.

2. Хурдан морины уралдаанч хүүхдэд учирч болзошгүй эрүүл мэндийн эрсдэлүүд

Эрүүл мэндийн байгууллага дээр хийгдсэн клиник бодит судалгаа болон бэртэл гэмтэлд хийгдсэн дүн шинжилгээн дээр үндэслэн хурдан морины уралдаанч хүүхдэд учирч болзошгүй бэртэл гэмтэл, эрүүл мэндийн эрсдлийг дараах байдлаар тодорхойлж болохоор байна. Үүнд:

Толгой болон мөчдийн гэмтэл. Уралдаанч хүүхдэд толгой болон мөчдийн гэмтэл элбэг тохиолддог болох нь клиник судалгааны баримт мэдээллээс илэрхий байна. Гэмтэл согог судлалын үндэсний төвийн бүртгэлээс иш татахад 2012 онд мориноос унаж гэмтэн уг төвд эмчлэгдсэн 326 хүүхдийн 73 нь тархины, 23 нь их биеийн, 180 нь дээд мөчний, 48 нь доод мөчний, 2 нь хавсарсан гэмтэл авсан байна. Энэ үзүүлэлтийг хувиар авч үзвэл 22.3% –ийг тархины гэмтэл, 55.2% –ийг дээд мөчдийн гэмтэл эзэлж байна. Энэ нь мориноос унах үедээ хүүхэд толгойгоороо газар харуулдан унах, мөн унах үедээ гараараа газар тулдагтай холбоотой. Мөн нас барсан хүүхдүүд бүгд тархины гэмтлээр нас баржээ.

Ясны хугаралт. Уралдаанч хүүхдэд мөн элбэг тохиолддог гэмтлүүдэд ясны хугарал, үений мултрал, яс булчингийн системийн гэмтэл, мэс засал шаардагдах яс булчингийн системийн гэмтэл, нуруу нугасны гэмтэл багтана. Эдгээр гэмтлүүдийн дийлэнх нь мориноос унах үед тохиолддог ба дээр дурдсанчлан бэртэл гэмтлийн дийлэнх хувийг дээд мөчний хугаралтын гэмтэл эзэлж байна.

Хөлдөлт, осголт. Хаврын уралдааны үеэр түгээмэл тохиолдож болох эрүүл мэндийн эрсдэл нь хөлдөлт, осголт юм. Хөлдөлттэй гэмтэлд хайруулах болон хөлдөх зэрэг гэмтлүүд орно. Хаврын уралдааны үед хүүхдэд дагжилт чичрүүдэс бий болж, арьс нь улайж хавдан, час час хийсэн мэдрэмж төрж, өвдөлт үүсдэг. Мөн хөл гар даарснаас мэдээ алдан бадайрах, хөл гар, тавхай





загатнах, өвдөх, хавдах болон цэврүү үүсэх шинж тэмдэг илэрнэ. Арьсны өнгө эхэндээ улаан байснаа гэмтэл даамжрах тутам хөх, ягаан өнгөтэй болж хүнд тохиолдолд үхжил үүсэх аюултай. Хамгийн түрүүнд чих, хамар өртөнө.

Хөлдөлтгүй гэмтэлд дагжилт чичрүүдэс, хөл гар даарснаас мэдээ алдан бадайрах зэрэг ордог. Хаврын улиралд энэ нь уралдаанч хүүхдэд элбэг тохиолддог бөгөөд уралдаж ирээд мориноосоо буусны дараа хөл бадайрч, алхахад төвөгтэй байж байгаад аажим зүгээр болох зэрэг шинжээр илэрч болно.

Амьсгалын замын өвчин. Хаврын уралдаан ихэвчлэн хоёр, гуравдугаар сард зохион байгуулагдаж байна. Эдгээр сарын дундаж хэмийг харвал хасах 6–15 хэмийн хүйтэн байна. Гэхдээ арван хоёр болон нэгдүгээр сар бол ид сунгаа болон тарны сарууд бөгөөд энэ саруудын дундаж хэм хасах 12–20 байдгийг мартаж болохгүй. Эдгээр саруудын хүйтний нөлөөлөл хүүхдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж осголт, хөлдөлтөөс гадна ханиад, томуу, хатгаа зэрэг амьсгалын замын өвчнөөр өвчлөх эрсдэл өндөр болдог. Осголт, хөлдөлтийн үед хүний амьсгалын дээд замд хүйтний нөлөө шууд үйлчилснээс цаашдаа уушигны хатгалгаар хүндрэх нь элбэг. Бие султай зарим хүүхдэд “нойтон уушги” хэмээн нэрлэдэг хүндрэл ч гарах талтай.

Дотор эрхтэний доргилт, өвчлөлт. Хурдан морины уралдаанд нэг өдөрт хэт хол зайг дээд хурдаар туулж байгаа хүүхдийн дотор эрхтэн доргих аюултай. Ялангуяа элэг сугсарагдах, ингэснээр элэг өвчлөн томрох, үрэвсэх, цөсний хүүдий сунах, бөөр унжих, улмаар бөөрний үрэвсэл үүсэх зэрэг сөрөг нөлөөллүүд үүснэ. Физиологийн өндөр ачааллын улмаас буюу тухайлбал хөдөлгөөн хэт ихэдсэнээс шээсний өнгө хувирах, бага зэрэг цустай гарах гэх мэт үзүүлэлтүүд байдаг.

Холын замд уралдах үед бөөр нь доргилт ихээр авсанаас бөөр унжих, ууцаар хөшиж өвдөх, цустай шээс гарах болон шээс ойр ойрхон хүрэх, эсвэл тасалдах, турах, хоолны дуршил буурах, ядрах зэрэг шинж тэмдгүүд илрэхээс гадна яваандаа бөөрний унжилт их болж, шинж тэмдгүүд даамжиран хүндэрч улмаар бөөрний бусад эмгэгүүд, бөөрний архаг үрэвсэл, бөөр чулуужих хүртлээ хүндэрдэг. Хүүхдэд уламжлалт монгол бүсийг бүслүүлдэггүй, эмээл хэрэглэхгүй байгаа зэрэг нь доргилтоос авах нөлөөллийн хэмжээг ихэсгэж байна. Ялангуяа хаврын уралдаанд газрын хөрс хөлдүү байдаг тул морины давхилт хатуу болдог учир илүү доргих магадлал өндөр болдог. Бөөрний эмгэгийн шинж тэмдэг хурцаар илэрдэггүй учир далд байдлаар явсаар насанд хүрэхэд бөөрний архаг өвчний суурь тавигдсан байх эрсдэл байдаг.

Хөвгүүдийн хувьд морь унах явцад төмсөгөө гэмтээх улмаар насанд хүрсэн үедээ үргүйдэлд хүрэх эрсдэлтэй. Охидын хувьд эмээлгүй морь унах явцад онгон хальсаа гэмтээх аюултай байдаг.

Нүд. Хүйтэн үед хүчтэй салхинд хамгаалах нүдний шилгүйгээр морь унаж уралдах үед хүүхдийн нүдний эвэрлэг бүрхэвч хөлдөх аюултай. Нүдний эвэрлэгийн хөлдөлт нь цасны моторт чаргаар болон цанаар гулгах, уулын цанаар өндөр хурдаар уруудах, нохой чарганы уралдаан зэрэг спортын үед тохиолддог эмгэг юм. Мөн хаврын хүйтэн улиралд морь унаж уралдаж байгаа хүүхдүүдэд тохиолдох бүрэн боломжтой. Энэ гэмтлийн үед нүдний хараа балартаж эхэлдэг бөгөөд ингэснээр тамирчин цаашид уралдаанаа үргэлжлүүлэх боломжгүй болдог байна.



Нүдний эвэрлэгийн хөлдөлт нь халуунд түлэгдсэн эвэрлэгийн адил шинж тэмдгийг үзүүлдэг бөгөөд гурван зэрэгт хувааж ангилдаг. Өнгөц хөлдөлтийн үед эвэрлэгийн гаднах бүрхэвчийн өнгөц хэсэг цайрдаг. Хоёрдугаар зэргийн хөлдөлтийн үед эвэрлэгийн гаднах бүрхэвч бүхэлдээ хөлдөж, хатуурдаг. Гуравдугаар зэргийн хөлдөлтийн үед нүдний алим хөлдөж, цусны судсанд мөсний талст үүсдэг байна. Энэ гэмтлийн үед эмчилгээ хэдэн долоо хоногоор үргэлжилдэг бөгөөд хүнд зэргийн хөлдөлтийн үед нүдний эдийн гэмтэл их хэмжээгээр үүссэнтэй холбоотойгоор мэс засал эмчилгээ хийх шаардлага гардаг.

Судалгаанд оролцсон нийт 529 хүүхдээс (95.6% эрэгтэй, 4.4% эмэгтэй) уралдааны явц дахь осол бэртэл, тэдний эрүүл мэндийн талаар асуусан асуултанд дүгнэлт хийсэн байдлыг дурдвал:

Судалгаанд оролцсон хүүхдүүдийн 277 нь буюу 52,3 хувь нь ямар нэг байдлаар мориноосоо унаж байсан бөгөөд унах болсон шалтгаан нь 121 хүүхэд замын хальтиргаанаас, 83 хүүхэд үлий нүхэнд морь нь бүдэрсэн, 53 хүүхэд морины болон тоос шороо их учир замаараа яваагүйгээс, 29 нь олом жирэм, хазаар, жолоо тасарсан гэсэн байна. Эдгээр мориноосоо унасан гэсэн хариулт өгсөн хүүхдүүдийн 196 нь ямар нэг байдлаар бэртэж гэмтсэн гэсэн хариултыг өгснөөс 51 хүүхэд толгой өвдөж, тархи доргисон, 55 хүүхэд биеийн хэсэг хөхөрч, шалбарч шархласан, 50 хүүхэд хөл гараа гэмтээж, хугалсан, 34 хүүхэд хөл, гар нүүр хацраа хөлдөөсөн, 9 нь нуруу, нугасаа гэмтээсэн гэсэн хариултыг тус тус өгсөн байх бөгөөд мориноос унах, бэртэж гэмтэх үедээ хамгаалалтын хувцасаа бүгдийг өмссөн байсан гэж 145 буюу 52.3 хувь, заримыг өмссөн байсан гэж 80 буюу 28,8 хувь, огт өмсөөгүй байсан гэж 52 буюу 18.7 хувь нь хариулсан байна.

Хаврын уралдааны үед болон уралдааны бэлтгэлийн үед бэртэж гэмтсэн даруй эмнэлгийн тусламж авч байсан уу? гэсэн асуултанд 44.8 хувь нь үгүй, 33.1 хувь нь заримдаа, 22.6 хувь нь тийм гэж хариулсан байх бөгөөд эмнэлгийн тусламж аваагүй шалтгааны 63.6 хувь нь ялимгүй гэмтэл байсан хэмээн хариулсан байна.

Сэтгэлзүйн эрүүл мэндийн эрсдэл. Хурдан морь унадаг хүүхдүүдийн сэтгэлзүйн байдал нь хаана хэний морийг унаж байгаа эсэхээс ихээхэн хамаарч байгаа нь хурдан морь унадаг хүүхдүүдтэй хийсэн ярилцлагын явцад сэтгэл зүйн тодорхойлолтыг гаргасан сэтгэл судлаачийн дүгнэлтээс тодорхой харагдаж байна. Өөрөөр хэлбэл гэртээ байж өөрийн эцэг эх, эмээ өвөөгийнхөө морийг унадаг хүүхдийн сэтгэл зүйн байдал, айлд байж хүний морийг унадаг хүүхдийн сэтгэл зүйн байдал нэн ялгаатай байгаа нь ажиглагдсан байна.

Хурдан морины уралдаанч нийт 529 хүүхдээс авсан судалгааны дүнгээс үзвэл, давхардсан тоогоор тэдгээр хүүхдүүдийн 235 нь өөрийн буюу эцэг эхийн морийг унадаг, 193 хүүхэд хамаатан садангийн, 124 хүүхэд мөнгөөр хүний морийг унадаг хүүхдүүд байв. Гэхдээ Улаанбаатар хотын Хан-Уул болон Налайх дүүрэг, Төв аймгийн Зуун мод, Зүүндэлгэр сумын судалгаанд оролцсон уралдаанч хүүхдүүдийн хувьд мөнгөөр хүний морь унадаг гэсэн хариулт нь бусад хариултаас илүү хувийг эзэлж, Төвөөс алслагдсан аймаг, сумдын уралдаанч хүүхдүүдийн хувьд өөрийн болон хамаатан садангийн морийг унадаг гэсэн хариулт давамгайлж байгаагаас дүгнэхэд хот суурин газар





амьдарч буй орлого багатай өрхийн хүүхдүүд орлого олох үүднээс хүний морь унах нь илүүтэй байгаа нь харагдаж байна. Асуулгад оролцсон хүүхдүүдээс “Хурдан морины уралдаанд оролцохдоо хаана амьдардаг/байрладаг вэ?” гэсэн асуултанд давхардсан тоогоор гэртээ амьдардаг гэж 196 хүүхэд, хамаатан садангийндаа гэж 153 хүүхэд, айлд байрладаг гэж 182 хүүхэд тус тус хариулсан байна. Харин уяач нар уралдаанч хүүхдээ хаана байрлуулдаг талаар асуухад өөрийн гэртээ гэж 83 буюу 90.2 хувь нь хариулсан байна.

Өөрийн гэртээ байж өөрийн эцэг эх, эмээ өвөөгийнхөө морийг унадаг хүүхдүүд өөртөө итгэлтэй, өөрийгөө илэрхийлэх ярианы чадвар сайн, харилцааны хувьд нээлттэй, цэгцтэй ярих чадвартай байгаа нь ажиглагдсан. Тэдгээр хүүхдүүд гэр бүлийн гишүүд болох аав, өвөө, ах нар нь морь уядаг учраас удам залгах уяач болох хүсэл мөрөөдөлтэй, морины талаар мэдлэг сайн, моринд хайртай, мөн морь унаж уралдахдаа дуртай, морь унадаг болсондоо өөрөөрөө бахархдаг байдлууд ажиглагдаж байв.

Айлд байж, хүний морийг унадаг хүүхдүүдийн хувьд өөртөө итгэх итгэл болон өөрийн үнэлэмж доогуур боловч аливаа зүйлд дасан зохицохдоо амархан, аливаа зүйлийг эерэгээр хийх хандлага харагдаж байгаа ч маш их зүйлд сэтгэл нь түгшиж айдаг, гэр бүлийн таагүй уур амьсгалаас шалтгаалсан сэтгэл зүйн түгшүүр өндөр, өөрийн ах эгч, дүү нарыг санадаг ба сайн байгаа эсэхэд эргэлзэж байнга санаа нь зовдог, гэр бүл нь мал байхгүй хэдий ч морины талаарх мэдлэг их, хурдны морь унадагаараа өөрөөрөө бахархдаг, сэтгэхүйн хувьд насны дунджаас доогуур хөгжилтэй байгаа нь ажиглагдсан.

“Хаврын уралдааны үед даарч, өлсөж цангадаг уу?” гэсэн асуултанд үгүй гэж 354 буюу 66.9 хувь, тийм гэж 72 буюу 12 хувь, заримдаа гэж 18.9 хувь нь хариулсан бол уяач нараас уралдаанч хүүхдийн хоол хүнс хувцас хэрэглэлийг хэн хариуцдаг талаар асуусан асуултанд 63 буюу 68.4 хувь нь уяач гэж, 26 буюу 28.2 хувь нь хурдан морины эзэн хэмээн хариулсан байна.

Уралдаанч хүүхдүүдээс “Уралдаан болон ажлын үед алдаа гаргавал морины эзэн/уяач хэрхэн ханддаг вэ?” гэсэн асуултанд 318 буюу 60.1 хувь нь яадаг ч үгүй, 157 буюу 29.6 хувь нь загнадаг, 24 буюу 4.5 хувь нь хаяа цохиж өшиглөдөг, 15 буюу 2.8 хувь нь морь унахыг хориглодог, 4 буюу 0.7 хувь нь хоол унд өгдөггүй хэмээн хариулсан байна. “Ер нь хавар уралдаан хийхгүй, зөвхөн зун уралддаг бол ямар вэ?” гэсэн асуултанд уралдаанч хүүхдүүдийн ихэнх нь буюу 56.5 хувь нь зөвхөн зун уралдаад, өвөл хавар хичээлдээ явж байвал зүгээр гэж хариулсан байна. Эдгээрээс дүгнэхэд уяачдын зүгээс уралдаанч хүүхэдтэй зүй бусаар харьцах, алдаа гаргасан үед нь шийтгэх зэрэг тохиолдол мэр сэр гардаг болох, мөн хүүхдүүд өөрсдөө зуны уралдааныг илүүд үздэг болох нь харагдлаа.

Манай оронд хурдан морь унах хүүхдүүдийн тоо жилээс жилд нэмэгдсээр байна. Одоогийн байдлаар жилд 40 орчим мянган хүүхэд хурдан морь унадаг гэсэн тооцоо байдаг. Эдгээр хүүхдүүд нар, салхи, бороо, шуурга, цастайг үл анхааран жилд болдог олон уралдаанд оролцон 6 насны морь унаж, морины наснаас хамаарч нэг удаад 16–50 километр зайг туулдаг гэж үзэхэд уралдаанч



хүүхэд жилдээ маш хол газар морин дээр явдаг болох нь харагдаж байна. Ийм ч учраас манай орноос бусад газар хурдан морийг зөвхөн насанд хүрсэн хүмүүс унахыг зөвшөөрдөг байна.

Хүүхдийн эрүүл мэндээ хамгаалуулах эрх нь зөрчигдөхийн зэрэгцээ, эрүүл энх өсч бойжих, эрүүл саруул иргэн болох замд аюул учирсаар байна. Бага насны хүүхдийг хүйтний улиралд хурдан морь унуулах нь хүүхдийн эрүүл мэнд, цаашдын амьдрал, амь насанд сөрөг нөлөө үзүүлдэг тул хурдан морины уралдаанч хүүхдүүдийн эрүүл мэндэд учирч буй сөрөг нөлөө, цаашдын үр дагаварын талаар нотолгоонд суурилсан эмнэлзүйн цогц судалгаа хийх зайлшгүй шаардлага бий болоод байгааг мөн дурьдах нь зүйтэй байна.

3.3 ХАВРЫН ХУРДАН МОРИНЫ УРАЛДААНЫ УРАЛДААНЧ ХҮҮХДИЙН СУРЧ БОЛОВСРОХ ЭРХИЙН АСУУДАЛ

Хурдан морины уралдаанч хүүхдийн сурч боловсрох эрх нь хаврын уралдааны үеэр зөрчигдөж байгаа нь сургуулийн нийгмийн ажилтан, багш, сурган хүмүүжүүлэгч (нийт 67 хүн) нараас авсан асуулгын болон ярилцлагын судалгааны дүнгээс тодорхой харагдаж байгаа юм. Бидэнд нэрээ хэлж бичлэг хийлгэхээс татгалзан зөвхөн яриа өгөхийг зөвшөөрсөн багшийн ярианаас иш татвал:

... Унаач хүүхдүүдийн тухайд аймаг орны иргэдийн хурлын дарга, аймгийн өндөрлөгүүдэд байдаг хүмүүс ерөнхийдөө хүүхдийг морь унуулж байгаа нь ажиглагддаг. Тэр даргын морь, тэрний унаач хүүхэд гэх мэтээр яригддаг. Тэгээд яаж хүүхдүүд хохирдог вэ? гэхээр хүүхдүүд маш олон хоног, сараар уралдаанд бэлдэхийн тулд сунгаа гэх мэтээр сургуулийн удирдлагад нь хэлж чөлөөлөгддөг, багш нарт чөлөө өгч болохгүй гэж сургуулийн удирдлага хэлдэг мөртлөө хэн нэгэн дарга утасдахад сургуулийн удирдлага менежерийг дуудаж тэр дарга яриад байна тэр хүүхдийг чөлөөлөөд явуул гэх жишээтэй.

Эцсийн эцэст сурган хүмүүжүүлэгч хүний зүгээс эцэг эхчүүдэд хандаж хэлэхэд хэдэн бор төгрөгний төлөө хүүхдүүдээ золиослоод байгаа юм шиг санагддаг. Хожим нь хүүхэд морь унаж яваад тархи толгойны хүнд гэмтэлтэй болох, унаж саажих өвчинтэй болох зэргээр насан туршдаа хохирох вий. Ямар ч мэдлэг боловсролгүй зөвхөн морь унасаар хүн амьдрахгүй шүү дээ. ...

Хурдан морины уралдаанч хүүхдийн хичээлийн хоцрогдол

“Сургуульд сурдаг уу?” гэсэн асуултанд асуулгад оролцогч бүх хүүхдүүд 100 хувь сургуульд сурдаг гэж хариулсан ба энэ нь судалгаа гол төлөв ерөнхий боловсролын сургуулиуд дээр хийгдсэнтэй холбоотой. Гэтэл багш нараас авсан асуулгын судалгаагаар хаврын уралдааны үеэр хүүхдүүд 30 хүртэл хоногоор хичээлээс чөлөө авах, таслах байдал ихээхэн ажиглагддаг, хурдан морины уралдаанч хүүхдийн сурлагын түвшин доогуур, чанартай боловсрол эзэмших эрх нь зөрчигдөж байгаа талаар дурдсан.





Судалгаанд оролцсон багш нарын 41.7 хувь нь хурдан морины уралдаанч хүүхэд хичээл үе үе тасалдаг, 35.8 хувь нь чөлөө авдаг, уралдаанч хүүхдийн сурлагын түвшингийн талаар багш нарын өгсөн үнэлгээнээс үзвэл 1 багш А–В, 9 багш В–С, 38 багш С–D, 19 багш D–F оноо авдаг гэсэн бол хүүхдүүдийн хичээлийн хоцрогдлын талаар багш нарын 43 хувь нь их, 46.2 хувь нь дунд, үлдсэн хувь нь бага хэмээн тус тус хариулсан байна.

Хичээлийг нөхөж заах, хоцрогдлыг арилгах арга хэмжээ авах нь сургууль болон багш нарын үүрэг хэдий ч багш нарын болон анги танхимын хүрэлцээ муу, цаг хугацааны асуудал зэргээс болоод боломжгүй байдаг, мөн давтлага хичээл хийлгэсэн ч үр дүн бага гардаг гэдгийг тайлбарлаж байсан. Энэ нь уралдаанч хүүхдүүд хоцорсон хичээлээ найзаасаа ихэнхдээ нөхөж авдаг гэсэн хариулттай нийцэж байлаа.

Хурдан морь унуулах шалтгаанаар хичээлээс чөлөө олгохыг хориглох талаар сургуулийн захиргаа, холбогдох албаны хүмүүсээс багш нарт даалгадаг хэдий ч хурдан морины эзэд нь тухайн аймаг сумынхаа нөлөө бүхий эрх мэдэлтэй хүмүүс байдаг тул хурдан морийг нь унаж уралддаг хүүхдийг нь хичээлээс чөлөөлж явуулах даалгавар өгч (тухайлбал утсаар), тэр даалгаварыг нь үг дуугүй биелүүлэх тохиолдол гардаг байна.

Хурдан морины уралдаанч хүүхдийн сургууль завсардалт

Хичээлээс хоцрогдож үеийн хүүхдүүдээс сурлагын дүнгээр мууд тооцогдох болсон хүүхдүүд хичээл ном сонирхохоо больж морь унаж амьдрах нь боломжтой, энэ чигээрээ байж болно гэсэн сэтгэхүйтэй болдог байна. Гэвч хурдан морь унах хүүхдийн нас, бие бялдарын хөгжлөөс шалтгаалан морь унаж уралдах нас нь (ихэвчлэн 12, 13 наснаас хурдны морь унахаа больдог) өнгөрсөн тохиолдолд сурсан сургуульгүй, эзэмшсэн мэдлэг боловсролгүй болсон хүүхдүүд тухайн уяач, эздийнхээ морь малны бусад ажлыг хийх, мал хариулах зэрэг ажлыг хийж амьдрахаас өөр замгүй болсноор сургуулиас завсардах нөхцлийг бүрдүүлдэг байна.

Мөн зарим тохиолдолд алслагдсан аймаг сумдаас хурдан морь унуулах нэрийдлээр эцэг эхээс нь салган өөр аймаг, сумд авчрах тохиолдол цөөнгүй байна. Өөрөөр хэлбэл эцэг эх нь нутагтаа оршин сууж байхад хүүхдийг нь шилжүүлж хурдан морь унах газрынх нь харьяа аймаг сумын сургуульд сургана гэж бүртгүүлдэг боловч цаасан дээр бүртгэлтэй сургуульд явдаггүй хүүхдүүд ялангуяа төвийн бүсэд хамаарч байгаа Төв аймаг, Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 19-р хороо буюу Өлзийт хороолол, Налайх дүүргийн сургуулиудад сүүлийн 5 жилийн хугацаанд нэмэгдсэн байна.

Хаврын уралдааны дараа сургуульд сурч байгаа хурдан морины уралдаанч хүүхдүүдийн анги дэвшин суралцах шалгалт болдог бөгөөд энэхүү шалгалтаар хүүхдүүдийн авсан дүнгийн үзүүлэлтээр тухайн сургуулийг үнэлж дүгнэдэг. Сургууль өөрийн амжилт чанараас татуулахгүйн тулд тэдгээр хүүхдүүдийн дүнг зохиомлоор өсгөн тавьдаг болох нь мөн судалгааны явцад багш нарын ярианаас ажиглагдаж байсан юм. Энэ нь эргээд чанаргүй боловсролын тухай асуудлыг бий болгож байдаг нь гарцаагүй юм.



Ийнхүү хүүхдийн сурч боловсрон, хөгжиж дэвших амьдралынх нь хамгийн чухал цаг мөчтэй давхцан олноор зохион байгуулагдах болсон хаврын хурдан морины уралдаан нь хүүхдийн сурч боловсрох эрхийн хүнд, хурц хэлбэрийн томоохон зөрчил болж байна.

3.4 ХУРДАН МОРИНЫ ХАВРЫН УРАЛДААН НЬ МОНГОЛ ТӨРИЙН УЛАМЖЛАЛТ ӨВ СОЁЛ МӨН ЭСЭХ

2010 оны 10 дугаар сард ЮНЕСКО-ийн Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн төлөөллийн жагсаалтад “Монголын уламжлалт баяр болох Наадам” бүртгэгдсэн.

Монгол Наадам буюу эрийн гурван наадам нь Монголын эртний уламжлалт баяр наадмын зан үйл гэж тодорхойлж өгсөн. Тухайн жагсаалтад бүртгүүлсэнээр эрийн гурван наадмын нэг болох хурдан морины уралдаан нь бөх, сур харваагийн нэгэн адил монголчуудын соёлын өв мөн болохыг олон улсын хамтын нийгэмлэгийн хувьд хүлээн зөвшөөрүүлсэн явдал болсон байна.


Үндэсний хэмжээнд УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалаар “Үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж хөгжүүлэх нь монгол үндэстний оршин тогтнохын үндэс, амин чухал дархлаа мөн” гэж тунхагласан.

Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн оршил хэсэгт “төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж... хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно” гэж заасан. Морин уралдаан нь төрт ёсны түүхэн уламжлал юм.

Иймээс ч төрийн бодлогын хувьд хурдан морины уралдаан нь төрийн хамгаалалтад байх үндэсний соёлын өвд багтах бөгөөд үндэсний наадам, уламжлалт тоглоом, наадгайн зан үйлийн хэлбэрийнхээ хувьд соёлын биет бус өв юм.

Харин эдгээр соёлын өвийг хамгаалахдаа тухайн салбарын олон улсын гэрээ, конвенцоор хүний эрхийн тухай олон улсын эрх зүйн одоо мөрдөгдөж буй баримт бичиг, ялангуяа Хүний эрхийн тухай 1948 оны түгээмэл тунхаглал, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай 1966 оны олон улсын пакт, Иргэний болон улс төрийн эрхийн тухай 1966 оны олон улсын пактыг иш үндэс болгон хандах ёстойг тэмдэглэсэн байдаг. Өөрөөр хэлбэл хурдан морины уралдаан нь соёлын өв гэж үзэж боловч хүний эрх, тэр дундаа хүүхдийн эрхийн асуудлыг үндсэн шалгуурын нэг болгон авч үзэх зайлшгүй шаардлагатай нь харагдаж байна.

Учир нь Монголчууд 20-р зууны төгсгөлөөр өвлийг өнгөрөөж хаврыг угтаж, урт уяа сойлго хийж, холхон зайд морь уралдуулах заншил, арга барилд шинэчлэлт хийж эхэлжээ. Хэдийгээр хурдан морийг уяж, сойх арга шинэчлэгдэж байгаа ч хурдан морины уралдааны гол субъект болох уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг орхигдуулж, өвөл, хаврын хасах градууд хурдан морь унуулж, аюултай ажил хөдөлмөр эрхлүүлж байна. Хурдан морины уралдаан нь монголын ард түмний төрт ёсны өв соёлын үнэт баяр цэнгээн байх уламжлалт хэв маягаасаа илүү өргөн цар хүрээтэй болж,





зөвхөн зун биш өвөл, хавар уралдаан зохиож, хүүхдийн амь нас, эрүүл мэнд, боловсролд сөргөөр нөлөөлөхүйц байдлаар бооцоотой гэх мэт хүүхдийн тэвчишгүй хүнд хөдөлмөрийн хэлбэрт шилжих хандлагатай байгаа, мөн хүүхэд унаж бэртэх, тэр бүү хэл амь насаа алдах хүртэл тохиолдол гарч байгаа тул олон улсын байгууллагууд болон монголын ард түмэн ч уралдаанч хүүхдийн эрхийн асуудалд анхаарал хандуулах болжээ.

Үндэсний төв архивын сан хөмрөгт хадгалагдаж буй (1803–1920 оны) Наадмын баримтын нийт 381 цуглуулга дансыг шүүж үзэхэд тухайн оныхоо 5–8 дугаар сард даншиг наадмаа хийж байсан нь тодорхой харагдаж байна. Мөн Хан Хэнтий уулын аймгийн Галшар уулын хошууны дансыг шүүж үзэхэд мөн тухайн оны 5–8 дугаар сард даншиг наадмаа хийж байжээ.

Монголчууд 20–р зууны төгсгөлөөр өвлийг өнгөрөөж хаврыг угтаж, урт уяа сойлго хийж, холхон зайд морь уралдуулах заншил, арга барилд шинэчлэлт хийж эхэлсэн хэмээн үздэг. Үүнээс үзвэл хаврын хурдан морины хаврын уралдаан нь зарим газарт ахуйн хүрээнд байсаар байсан ба 1995 оны дундуураас олныг хамарсан байдлаар зохион байгуулагдаж, 2004 оноос албан ёсны болгож Засгийн газрын тогтоолоор зохион байгуулагдах болжээ.

Үүнээс үзвэл хурдан морины уралдаан нь төрт ёсны түүхэн уламжлал, өв соёл мөн боловч өвөл, хаврын улиралд зохион байгуулах нь төрт ёсны түүхэн уламжлал, өв соёл хэмээн үзэх бодит үндэслэлгүй байна. Харин ахуйн чанартай багахан уралдаанууд зохиогдож байсныг судалгааны явцад өндөр настнууд нотолсон болно.

Иймд хаврын уралдааныг төрт ёсны болон ахуйн чанартай гэж ангилж үзэн ялгамжтайгаар зохицуулах нь зүйтэй байна.

3.5 ХАВРЫН УЛИРАЛД ХУРДАН МОРЬ УНАХ НЬ ХҮҮХДИЙН АЮУЛТАЙ ХӨДӨЛМӨР МӨН ЭСЭХ

Насанд хүрээгүй бага насны хүүхэд хурдан морь унах нь хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр хэмээн ойлгох ойлголт түгээмэл болж байна. Энэ байр суурьтай нийлэх нэг хэсэг байхад нийлэхгүй ч байр суурь байна. Хурдан морины уралдааныг хүүхдийн хөдөлмөрийн хэлбэр мөн эсэх асуудлыг авч үзэхийн тулд уралдаанч хүүхдүүд морины уралдаанд хөдөлмөрийн харилцаанд үндэслэн оролцож байна уу, эсхүл цалин хөлсгүйгээр өөрийн сонирхол, ур чадварт хөтлөгдөн оролцож байна уу (спортын адил), уралдаанч хүүхэд хөдөлмөрийн харилцаанд оролцож байгаа гэж үзвэл хөдөлмөрийн насны доод хязгаарын асуудал зэрэг олон асуудлыг авч үзэх шаардлагатай болно.

Энэхүү судалгааны ажлын хүрээнд хаврын улиралд хурдан морь унах нь хүүхдийн аюултай хөдөлмөр мөн эсэх тал дээр илүүтэй анхаарч, энэ асуултад хариу олох зорилгыг тавьсан.

Судалгааны явцад хурдан морины уралдаанч хүүхдэд Хөдөлмөрийн тухай хуульд заасан насанд хүрээгүй боловч тогтсон цалин хөлс авч тодорхой хугацаанд тодорхой нөхцөлтэйгөөр хөдөлмөрлөж байгаа нь дараах уяачын ярианаас тодорхой болж байгаа юм.



Сүхбаатар аймгийн Баруун–Урт сумын уяачтай хийсэн ярилцлагаас...

... Хурдан морь унуулах хүүхдээ найз нөхдөөрөө дамжуулж олж байна. Би найзынхаа дүүгийн хүүхдийг хөлсөөр авч байна. ...

... Бага овооны наадамд хүүхдэд нэг удаад морь унуулахад 50,000 төгрөг нөгөө хүн мөнгөгүй бол багадаа 40,000 төгрөг, тэгээд аймгийн наадамд айрагдвал хүүхэд өөрөө бай шагналаа авна. Бас 10 дотор орвол 70,000–80,000 төгрөг өгнө.

Хурдан морио унуулж байгаа хүн бол 250,000–400,000 төгрөг өгч байна. Манай энэ хавьд бол бүтэн жилийн турш сар бүр 250,000 байдаг. Ер нь 250,000 төгрөгнөөс доош байдаггүй. ...

Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 182 дугаар конвенцийн 3 дугаар зүйлийн (d) хэсэгт тодорхойлсоноор “хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр” гэдэг тодорхойлолтод “ажлын шинж чанар, түүнийг гүйцэтгэх нөхцөл нь хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд хор нөлөө үзүүлэх ажил”–ыг (3) багтаасан байна.

Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 138 дугаар конвенцид хөдөлмөр эрхлэх насны доод хязгаар нь бүрэн бус дунд боловсрол эзэмших нас байх бөгөөд ямарч тохиолдолд 15 наснаас доошгүй, өсвөр үеийнхний эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй ажлын хувьд 18 наснаас доошгүй байна гэж тус тус заасан байна. Цаашилбал, 182 дугаар конвенцийн 3 дугаар зүйлийн (d) хэсэгт заасан аюултай ажлын төрлийг холбогдох олон улсын хэм хэмжээ, ялангуяа Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай 1999 оны зөвлөмжийн 3, 4 дэх хэсгийн заалтыг харгалзан үзсэний үндсэн дээр үндэсний хууль тогтоомжоор, эсхүл ажил олгогч болон ажилчдын байгууллагатай зөвшилцсөний дараа эрх бүхий байгууллагаас тогтоосон хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр, түүний төрлүүдийн жагсаалтыг үе үе хянаж, шинэчилж байхыг гишүүн улсад үүрэг болгосон байдаг.

Энэхүү судалгааны явцад уралдаанч хүүхдийн хийж гүйцэтгэх ажил нь морь унаж уралдах, үүнийхээ хариуд сард 250.000 болон түүнээс дээш төгрөгийн цалин хөлс авахаар тохиролцож байгаагаас дүгнэвэл хөдөлмөрийн харилцаа бий болсон байна гэж үзэх бүрэн боломжтой байна. Харин өөрийн гэр орондоо уламжлалт хэлбэрээр уралдаж байгаа хүүхдүүдийн хувьд хөдөлмөрийн эрх зүйн харилцаа үүсээгүй байна.

УНН
СУДАЛГААНЫ САН





Энэхүү судалгааны баримтууд хаврын улиралд болж буй уралдаанд бага насны хүүхдүүд эрүүл мэндийн өндөр эрсдэлтэй нөхцөлд оролцож байгаа, мөн тэдний сурч боловсрох эрх нь ихээхэн зөрчигдөж буйг нотолж байгаа бөгөөд дараах үндэслэлүүд дээр тулгуурлан хаврын морин уралдааныг хүүхдийн аюултай хөдөлмөр гэж тодорхойлох боломжтой байна.

- Насны хувьд, хурдан морь унаж байгаа хүүхдүүдийн ихэнх нь 7–10 настай буюу хэт бага насны хүүхдүүд байгаа байдал,
- Хаврын уралдаан зохион байгуулагдаж байгаа нөхцөл байдал нь уралдаанч хүүхдийн амь нас, эрүүл мэндэд нь шууд эрсдэл бий болгож байгаа байдал,
- Хаврын уралдаан нь уралдаанч хүүхдийн боловсролд сөргөөр нөлөөлж байгаа байдал. Хаврын улиралд сургуулийн насны хүүхдүүд хичээлтэй байдаг бөгөөд хаврын хурдан морины уралдаанд оролцож байгаа хүүхдүүд хичээлээс 7–30 хонгогийн хугацаагаар чөлөө авах, таслах зэрэг асуудал түгээмэл байгаа нь үеийн хүүхдүүдээс сурлагаар хоцрох, цаашилбал хичээл номд дургүй болох сургууль завсардах хүртэл сөрөг үр дагаварыг дагуулсаар байдаг.
- Бооцоот уралдаан зохиох зэргээр хурдан морины хаврын уралдаан нь ашгийн төлөө үйл ажиллагаа болж байна. Хурдан морины уралдаанч хүүхдийг хурдан морины эзэд болон эрх бүхий хүмүүс төлбөр төлж хөлсөөр ажиллуулах явдал нийтлэг болсон нь судалгаагаар тогтоогдож байгаа боловч хурдан морины эзэд болон уралдаанч хүүхдийн хоорондын гэрээ хэлэлцээрт ямар ч хяналт байхгүй байна. Ийнхүү хавар хурдан морь унаснаас уралдаанч хүүхдэд учирч болох эрүүл мэнд, сэтгэл зүйн болон боловсролын эрсдэлүүд дээр үндэслэн хаврын улиралд бага насны хүүхэд хурдан морь унаж уралдаанд оролцох нь хүүхдийн аюултай хөдөлмөр мөн юм гэсэн дүгнэлтэд хүрч байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



ДӨРӨВ. ДҮГНЭЛТ



Нэг. Хавар хурдан морь унаж байгаа хүүхдүүдийн дийлэнх нь 7–10 насны хүүхдүүд байгаа бөгөөд ихэнх нь эрэгтэй хүүхэд байгааг судалгааны хүрээнд зохион байгуулсан нөхцөл байдлын судалгаа болон уралдаанч хүүхдүүдтэй хийсэн ярилцлага судалгаанаас харахад илт байв. Эдгээр хүүхдүүд нь хурдан морь унаснаар өөрт бий болж байгаа эрүүл мэндийн эрсдэл болоод нийгэм сэтгэл зүйн аюулыг ухамсарлах насанд хүрээгүй байгаа, мөн хурдан морь унах нь тэдний хувьд сонирхол төдийгүй түүгээрээ бахархах сэтгэгдэлтэй байгаа нь ажиглагдаж байлаа.

Манай улс хүүхдийн эрхийг хамгаалах олон улсын гэрээ конвенцид нэгдэн орсон боловч үүний дагуу дотоодын хууль тогтоомжоо боловсронгуй болгох үйл ажиллагаа төдийлөн бүрэн хангагдаагүй байна. Өөрөөр хэлбэл эдгээр хурдан морины уралдаанч хүүхдийн эрхийг хамгаалах эрх зүйн тогтолцоо манай улсад одоогоор байхгүй байна.

Эдгээр хүүхдийн цөөнгүй нь эрүүл аюулгүй өсөж бойжих, сурч боловсрох эрх нь зөрчигдөөд зогсохгүй хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрт тооцогдох хүнд аюултай орчин нөхцөлд морь унаж уралдаж байгаа нь судалгаагаар тогтоогдож байна.

Мөн уралдаанч хүүхдийн эрүүл мэнд, амь нас нь баталгаагүй байгаа нь хурдан морины уралдааны зохион байгуулалт болоод уралдаан болох бүрт хүүхэд унаж бэртэх, цаашилбал амь насаа алдах тохиолдол гарч байгаагаас илэрхий харагдаж байна.

Хурдан морины уралдаанч хүүхэд эрүүл мэндээрээ хохироход уяач, эцэг эх нар хоорондоо тохиролцоод эмчилгээний зардлыг төлөх төдийгөөр өнгөрөх, амь насаа алдсан тохиолдолд хариуцлага хүлээх болон хүлээлгэх эзэнгүй, хэн нэгэн буруутай этгээдийг тогтоож хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалт байхгүй байгаа нь хүүхдийн эрхийн ноцтой зөрчил болж байна.

Хоёр. Өвөл, хавар хурдан морь унаж байгаа хүүхэд мориноос унаж гэмтэн эрүүл мэндээрээ хохироод зогсохгүй уралдах болон бэлтгэл сунгаа хийж байхдаа ч эрүүл мэндээрээ хохирч байдаг нь эрүүл мэндийн эрсдлийн судалгаагаар тогтоогдож байна.

Хаврын хурдан морины уралдаан нь зохион байгуулагдах үеийн цаг агаарын байдал, уралдааны зам болон зохион байгуулалт, уралдаанч хүүхдийн насны байдал нь хүүхдийн эрүүл мэндийн





эрсдлийг улам бүр нэмэгдүүлж, хүнд тэвчишгүй, аюултай хөдөлмөр эрхлэлтэд тооцогдох нөхцлийг бий болгож байна.

Хурдан морины уралдаанч хүүхдийн уралдааны болон бэлтгэл сунгааны үед байрлах орон байр болон хаана амьдарч байгаагаас шалтгаалан өлсөж цангах, даарах, өөр айлд амьдрах, морь унаж уралдахын зэрэгцээ морины ажил хийх зэрэг нь хүүхдийн сэтгэлзүйн хувьд хүнд нөхцөл болох нь уралдаанч хүүхдүүдийн сэтгэлзүйн тодорхойлолтоос харагдаж байна. Эцэг, эхээсээ хол айлд морь унах гэж ирсэн хүүхдүүд нь туслах уяач нэртэй залуучуудтай хамт амьдарснаар сэтгэхүйд нь өөрчлөлт орж, хараал хэлэх, тамхи татах зэргээр хүмүүжилд нь сөрөг нөлөөллүүд гарч байгааг багш нар хэлж байв.

Гурав. Хурдан морь унадаг хүүхдүүдийн дийлэнх нь хурдан морийг сонирхолоороо унадаг хэмээн хариулж байгаа хэдий ч түүний ар гэр, амьдралын түвшин, гэр бүлийн анхаарал халамж, эцэг эхийн боломж бололцоо зэргээс ихээхэн хамаарч энэхүү замыг сонгож байгаа нь тодорхой байна.

Хурдан морь унаж байгаа хүүхдүүд нь 6–16 насны буюу бие даан бусадтай хэлцэл хийж, өөрийгөө бүрэн төлөөлөх чадамжгүй насан дээрээ байгаа бөгөөд тэднийг морь унах сонирхол дээр нь үндэслэн түүний эцэг эх, уяач нар хоорондоо тохиролцож, морь унасан хөлсөнд өгөх мөнгийг нь амьжиргааны түвшингээр дунд болон түүнээс доогуур орлоготой эцэг, эх нь авч амьжиргаагаа залгуулдаг. Харин хүүхдэд оногдох шан харамж нь ойр зуур чихэр, ундаа, хуушуур, бүр ихэдлээ гэхэд хичээлийн хувцас, хэрэгслээр нэг удааг хангах төдийхнөөр хэмжигдэж байгаа юм. Энэ нь хүүхдийн хөдөлмөрийг мөлжиж байгаа хэлбэр мөн.

Дөрөв. Хаврын хурдан морины уралдаанд хүүхдийг хичээл, сургуулиас нь чөлөө авах, таслуулах зэргээр хөндийрүүлж, хоцрогдуудах, сурлагын түвшинг бууруулах, цаашилбал хичээл сургуульд дургүй болж сургуулиас гарах, завсардах зэрэг сөрөг асуудлуудыг дагуулсаар байна. Энэ нь эдгээр хүүхдүүд өсч том болон цаашид сурч боловсрох боломжийг бага наснаас нь үгүй хийж, амьдралын баталгаагүй болгож байгаа явдал юм.

Тав. Хаврын хурдан морины уралдаан нь аймаг, хошууны бүртгэлийн дансанд бүртгэгдсэн, нийтийг хамарсан төрт ёсны түүхэн уламжлал гэдэг нь архивт хийсэн судалгаагаар тогтоогдохгүй байна. Харин ярилцлагын явцад ахуйн чанартай уралдаанууд болж байсныг гэрчилж байна. Өнөөгийн зохион байгуулагдаж буй уралдаануудын ихэнх нь уламжлалт шинж чанараа алдсан шинэ төрлийн уралдаан байна. Тухайлбал, автомашинаар дагах, уралдах морьдын тоо ихэссэн байна.

Зургаа. Бооцоо тавих, алдар цол олгох, өндөр шагнал зарлах, уралдааны тоог олшруулах нь зохион байгуулалтыг сулруулах үндсэн нөхцөл болж байна. Ахуйн чанартайгаар морины ажлаа хийх боломж нь нээлттэй байна.





Долоо. Хаврын уралдаанд зохицсон хамгаалалт, хувцас хэрэгсэл байхгүй байна. Тухайлбал, хамгаалалтын малгайн дотор ноосон малгай өмсөхөөр таагүй байдаг гэдэг үндэслэлээр хүүхдүүд нэг бол малгай эсхүл хамгаалалтын малгай хоёрын аль нэгийг сонгох шаардлагатай болдог гэж олон хүүхэд ярьж байв.

Найм. Хаврын уралдааныг Морин Спорт уяачдын холбоо ТББ зохион байгуулдаг гэж иргэд ойлгодог байна. Энэ холбоо нь нийтийн эрх зүйн этгээд биш бөгөөд ТББ-ын статустай гэдгийг мэдэхгүйн улмаас энэ байгууллагаас гаргасан дүрэм, журмыг дагаж мөрдөх, уг байгууллагаас зохион байгуулсан уралдаанд оролцох гэж бэлтгэж байна хэмээн олон газруудад дур дураараа уралдаан зохион байгуулдаг байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



ТАВ. ЗӨВЛӨМЖ



Судалгааны үр дүнгээс уралдаанч хүүхдийн эрхийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх дараах зөвлөмжийг судалгааны багийн зүгээс гаргаж байна.

1. Хурдан морины уралдаанч хүүхдийн эрхийг хамгаалах дотоодын эрх зүйн орчныг сайжруулахтай холбоотойгоор:

- Хурдан морины уралдаан болон бэлтгэл, сунгааны үеэр хүүхэд мориноос унасан, хурдан морины уралдаантай холбоотойгоор ямар нэг байдлаар бэртэж гэмтсэн, хохирсон тохиолдолд орон нутгийн захиргаанд заавал мэдээлж, буруутай этгээдийг тогтоож, хариуцлага хүлээлгэдэг тогтолцоог бий болгох.
- Хурдан морины уралдаан зохион байгуулагдаж буй морин уралдааны замаар зөвхөн эмнэлэг, цагдаа, зохион байгуулагчид болон хэвлэл, мэдээллийн гэсэн үндсэн дөрвөн төрлийн автомашинаас өөр тээврийн хэрэгсэл явуулахгүй байх талаар Монгол Улсын замын хөдөлгөөний дүрэмд нэмэлт оруулах;
- Хаврын хурдан морины уралдааныг зохион байгуулахад Ус, цаг уур, орчны шинжилгээний газартай хамтран ажиллаж цаг агаарын урьдчилсан мэдээ болон уралдаан болох газрын орчин нөхцөлийг урьдчилан тооцоолсон байх;
- Хаврын морин уралдаанд ямар ч хэмжээгээр бай, медаль, шагнал, уяачдад цол хэргэм олгохыг бүр мөсөн хориглох. Ингэснээр өвөл, хаврын улиралд болж байгаа олон уралдааныг цөөрүүлэх боломжтой бөгөөд морь уралдуулах зөвшөөрөл олгох нөхцөл журмыг нарийвчлан боловсруулж, бай, шагнал олгосон тохиолдолд захиргааны хариуцлага оногдуулах зохицуулалтыг бий болгох. Харин хавар ахуйн чанартайгаар морины ажил хийх эрх нь нээлттэй байх.
- Хурдан морины уралдаанч хүүхдийн эрхийн эрх зүйн байдлыг тодорхой болгож, олон улсын гэрээ конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэх үүднээс хурдан морь унахад тохиромжтой бие бялдар, нас, оюун ухааны хувьд өөрийн болоод бусдын үйлдлийг ойлгох, өөрт үүсч болох





эрсдлийг бүрэн ойлгож, ухаарах насанд хүрсэн үед нь хаврын хурдан морины уралдаанд оролцуулах, өөрөөр хэлбэл 18 наснаас дээш насныхан уралддаг хүйтний улирлын морины уралдааны шинэ төрлийн спорт, түүний эрх зүйн зохицуулалтыг бий болгох;

- Одоо үйлчилж буй хууль, тогтоомж стандартаар уралдаанч хүүхдэд үүрэг болгосон заалтуудыг хасч, уяачид үүрэг хүлээлгэх;
- Хүүхдээ хавар хурдан морь унуулж, хөлс мөнгөөр нь амьжиргаагаа залгуулж байгаа эцэг эх, асран хамгаалагчид хариуцлага тооцох;
- Хаврын уралдаанд оролцохоор хөлсөөр ажиллаж буй хүүхдүүдийн хөдөлмөрийг хүүхдийн хөдөлмөр хэмээн хүлээн зөвшөөрч, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр, түүний төрлийн жагсаалтыг Засгийн газар шинэчлэн батлах, үүнд насанд хүрээгүй хүүхэд хөлсөөр айлд хурдан морь унах нь хүүхдийн тэвчишгүй хэлбэрийн нэг болох асуудлыг нэг мөр болгох.
- Дотоодын хууль тогтоомжийг олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүрэг хариуцлагын дагуу шинэчлэн боловсруулах ажлыг эрчимжүүлэх.
- Хурдан морины уралдаан зохион байгуулдаг, хянадаг нийтийн эрх зүйн этгээд бий болгох.

2. Хурдан морины хаврын уралдаанд уралдаанч хүүхдийн эрүүл мэндийн эрсдэл болон боловсрол завсардалтыг бууруулах зорилгоор:

- Хаврын уралдаанд бага насны хүүхдийг оролцуулахгүй байх, насны хязгаарыг нарийвчилсан судалгаанд үндэслэн тогтоох;
- Улирлын амралтаас бусад хичээлийн өдрүүдэд ямар ч тохиолдолд уралдаан зохион байгуулахгүй байх.
- Хаврын уралдаанд оролцож байгаа хэдэн насны уралдаанч хэдэн градуссын дулаанд өдөрт хэдэн км замыг туулж уралдаж болох хязгаар стандартыг нарийвчилсан судалгааны үндсэн дээр тогтоох,
- Морин уралдаан зохион байгуулах хугацааг хүүхдийн эрүүл мэндтэй уялдуулан тогтоож, тогтсон хугацаанд тохиолдох цаг агаарын аюулт үзэгдэл болох хүйтрэлт, тоосжилт, халалт, цасан болон шороон шуурга, ширүүн бороотой зэрэг үед уралдааныг тохиромжтой үе хүртэл хойшлуулдаг байх журмыг боловсруулах. Энэ нь бүс нутаг тус бүрийн онцлогт тохирсон, тэр нутаг орны иргэдийн болон уралдаанч хүүхдүүдийн санал бодлыг тусгах,
- Хурдан морины уралдааны замын стандартыг бий болгож уралдаан болох бүрт морины комисс, хүүхдийн эрхийн төлөө байгууллагатай хамтран үзлэг шалгалт хийж баталгаажуулах, стандартын бус зам дээр морь уралдуулахыг хориглох шийдвэр гаргаж байх,





- Хурдан морины уралдаанч хүүхдэд уралдааны өмнө болон бэлтгэл сунгааны үед учирч болох эрсдлийг тайлбарлаж, ойлгуулах, заавал тэр өдрөө хурдан морь унахгүй байж болох талаар сануулах,
- Хурдан морины уралдаан, сунгааг тээврийн хэрэгслээр дагахыг нэг мөр хориглох,
- Цаг уурын байдлаас шалтгаалан газарзүйн бүсчлэл хийж, уг бүсчлэлийн дагуу тодорхой хугацаанаас эхэлж тухайн аймаг, бүсийн уралдаануудыг зохион байгуулж эхлэх хугацааг тухайн аймаг, сумын удирдлагуудад эрх олгон хуульчилж өгөх,
- Хурдан морины уралдаанч хүүхдэд учирч болох гэмтэл, бэртлийн талаар дэлгэрэнгүй нарийн судалгааг эмнэлгийн байгууллагууд өргөн цар хүрээтэй хийх,
- Хурдан морины эзэд уралдаанч хүүхдээр морио унуулах болон гэртээ байлгаж морь маллуулахаар бол иргэний шилжилт хөдөлгөөнийг хийлгэж, эцэг эх, асран хамгаалагчидтай нь хамт амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, бичгээр гэрээ хийх, гэрээнд хүүхдийн эрүүл мэндэд хохирол учирвал хэрхэн нөхөн төлөх заалтуудыг гэрээнд тусгаж, уяач хүүхдийн эрхийг зөрчихөөс сэргийлэх, зөрчсөн тохиолдолд хүлээх хариуцлагыг тусгах.
- Нэг уралдаанд хэдэн морь зэрэг уралдаж болох тоог тогтоож өгөх зэрэг зөвлөмжүүдийг гаргаж байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН





ЗУРГАА. ХАВСРАЛТ

ХАВРЫН ХУРДАН МОРИНЫ УРАЛДААН БА УРАЛДААНЧ ХҮҮХДИЙН ЭРХ СЭДЭВТ АСУУЛГЫН СУДАЛГААНЫ НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Хаврын хурдан морины уралдаан ба уралдаанч хүүхдийн эрх сэдвийн хүрээнд хийгдсэн асуулгын судалгааг судалгааны ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу сонгогдсон Төв аймгийн Зуунмод болон Зүүндэлгэр сум, Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 19-р хороо, Өлзийт хороолол, Налайх дүүрэг, Булган аймгийн Булган, Бугат, Хишиг-Өндөр сум, Орхон аймгийн Баян-Өндөр сум, Хэнтий аймгийн Чингис хот болон Сүхбаатар аймгийн Баруун-Урт, Эрдэнэцагаан сум зэрэг 6 газарт хийсэн болно.

Судалгааны ажлын хүрээнд асуулгын судалгаанд нийт Хурдан морины уралдаанч хүүхэд 529, уяач 102, багш, сурган хүмүүжүүлэгч 67, эмч, эмнэлгийн ажилтан 15, иргэн 85 нийт 798 хүн оролцсон болно.

Асуулгын судалгааны гол зорилго нь Хаврын хурдан морины уралдаан дахь Хурдан морины уралдаанч хүүхдийн талаарх ерөнхий мэдээлэл, нийгэм сэтгэлзүй, биологийн болон бусад аюулгүй байдал, боловсролын талаарх мэдээллийг гаргаж, хүүхдийн эрхийн зөрчил байгаа эсэхийг тогтоох явдал юм.

Хаврын хурдан морины уралдаан дахь хүүхдийн эрх судалгааны хүрээнд хийгдсэн асуулгын судалгааг нэгтгэн дүгнэвэл:

Судалгаанд оролцогч уралдаанч хүүхдүүдийн 339 буюу 64 хувь нь 10–13 настай, 95.6 хувь нь эрэгтэй байна. Эдгээр хүүхдүүдийн 362 буюу 68.4 хувь нь 5–7 настайгаасаа хурдан морь унаж уралдаж эхэлсэн байна.

Судалгаанд оролцогч уралдаанч хүүхдүүдийн 235 буюу 44,4 хувь өөрийн буюу эцэг эхийн, 193 буюу 36.4 хувь нь хамаатан садангийн, 124 буюу 23.4 хувь нь мөнгөөр хүний морийг унадаг гэж хариулсан байна. Гэхдээ Улаанбаатар хотын Хан-Уул болон Налайх дүүрэг, Төв аймгийн Зуун мод, Зүүндэлгэр сумын судалгаанд оролцсон уралдаанч хүүхдүүдийн хувьд мөнгөөр хүний морь унадаг гэсэн хариулт нь бусад хариултаас илүү хувийг эзэлж, Төвөөс алслагдсан аймаг, сумдын уралдаанч



хүүхдүүдийн хувьд өөрийн болон хамаатан садангийн морийг унадаг гэсэн хариулт нь давамгайлж байгааг асуулгын судалгааны нэгдсэн хүснэгтээс харж болно.

Асуултанд оролцсон нийт хүүхдүүдийн 87.3 хувь нь сонирголоороо буюу хурдан морь унах дуртай гэсэн бол 9.2 хувь нь мөнгө олохын тулд хурдан морь унадаг гэсэн хариултыг сонгосон байна.

Хурдан морь унаж байгаа хүүхдүүд нь 6–16 насны буюу бие даан бусадтай хэлцэл хийж, өөрийгөө бүрэн төлөөлөх чадамжгүй насан дээрээ байгаа бөгөөд тэднийг морь унах сонирхол дээр нь үндэслэн түүний эцэг эх, уяач нар хоорондоо тохиролцож, морь унасан хөлсөнд өгөх мөнгийг нь амьжиргааны түвшингээр дунд болон түүнээс доогуур орлоготой эцэг, эх нь авч амьжиргаагаа залгуулдаг. Харин хүүхдэд өөрт нь ойр зуур чихэр, ундаа, хуушуур, хувцас, хэрэгслээр хангах төдийхнөөр хэмжигдэж байгаа юм. Хүүхдийн эрхийн тухай хуульд хүүхэд асран хамгаалуулах, тэжээн тэтгүүлэх эрхтэй байтал эрх нь үүрэг болж, эцэг эхийнх нь үүрэг эрх болж хувирсан байх үрвүү үзэгдлийн нэгэн жишээ болсон байгаа нь судалгааны явцад ажиглагдсан.

2. Багш, сурган хүмүүжүүлэгч нарын асуулгын судалгааны дүнгээс харвал хурдан морины уралдаанч хүүхдийн ар гэрийн амьдралын түвшин сайн гэж 4.4 хувь, дунд гэж 44.7 хувь нь, дундаас доогуур гэж 50.7 хувь нь хариулсан. Мөн Хурдан морины уралдаанч хүүхдүүдэд ар гэрийнхэн нь хэр анхаарал халамж сайн тавьдаг гэж 3 буюу 4.4 хувь нь, дунд гэж 40 буюу 59.7 хувь нь, муу гэж 24 буюу 35.8 хувь нь хариулсан байна.

“Сургуульд сурдаг уу? /Хэд дүгээр анги/” гэсэн асуултанд 100 хувь сургуульд сурдаг гэж хариулсан. Учир нь судалгаа гол төлөв Ерөнхий боловсролын сургуулиуд дээр хийгдсэн. Налайх дүүрэг орчимд болсон Шийрхайрханы тахилгын хурдан морины уралдаан дээр хийгдсэн судалгаанд оролцогчид ч мөн сургуульд сурдаг хэмээн хариулсан байна. Багш нараас авсан асуулгын судалгаагаар хурдан морь унадаг гэсэн шалтгаанаар сургуулиас завсардсан хүүхэд байгаа эсэх талаарх асуултанд 89.3 хувь нь байхгүй, 10.7 хувь нь байгаа гэж хариулсан байна.

Хичээл, шалгалтандаа ихэвчлэн ямар дүн авдаг эсэх талаарх асуултанд хурдан морины уралдаанч хүүхдүүдийн 177 буюу 33.4 хувь нь А–В, 228 буюу 43.1 хувь нь В–С, 102 буюу 19.2 хувь нь С–D, 16 буюу 3 хувь нь D–F хариулсан бол Хурдан морины уралдаанч хүүхдийн сурлагын түвшингийн талаар багш нараас авсан судалгаагаар эсрэгээрээ 1 буюу 1.4 хувь нь А–В, 9 буюу 13.4 хувь нь В–С, 38 буюу 56.7 хувь нь С–D, 19 буюу 28.3 хувь нь D–F гэж хариулсан байна.

Хаврын уралдаанд оролцохдоо хичээлээсээ чөлөө авдаг гэж 64.2 хувь нь, тасалдаг гэж 1.5 хувь нь, хааяа чөлөө авдаг, хааяа тасалдаг гэж 34.2 хувь нь хариулсан байна. Хичээлийн хоцрогдлоо нөхөж авдаг байдлаа хамгийн их нь буюу 43.2 хувь нь найзаасаа, 31 хувь нь багшаасаа хичээлээ нөхөж авдаг гэж хариулсан байна. Харин багш нараас авсан судалгаагаар хурдан морины уралдаанч хүүхдүүд хичээл хэр их тасалдаг вэ гэсэн асуултанд судалгаанд оролцсон багш нарын үе үе тасалдаг гэж 41.7 хувь, чөлөө авдаг гэж 35.8 хувь нь хариулсан байна. Хурдан морины уралдаанч хүүхдийн хичээлийн хоцрогдолын талаар 43 хувь нь их гэж хариулсан бол 46.2 хувь нь дунд зэрэг



гэж хариулсан байна. Хичээлийн хоцрогдол арилгах арга хэмжээ авдаг эсэх тийм боломж сургууль болон багш нарт байдаг эсэх талаар байдаг гэж 49.2 хувь нь, байдаггүй гэж 50.8 хувь нь хариулсан байна.

Хурдан морины уралдаанч хүүхдүүд “Хурдан морины уралдаанд оролцохдоо хаана байрладаг вэ?” гэсэн асуултанд айлд гэж 182, гэртээ гэж 196, хамаатан садан гэж 153 хүүхэд сонгосон бол уяач нар уралдаанч хүүхдээ хаана байрлуулдаг талаар асуусан асуултанд өөрийн гэртээ гэж 83 буюу 90.2 хувь нь хариулсан байна.

Хурдан морины уралдаанч хүүхдүүдээс асуусан “Хаврын уралдааны үед даарч, өлсөж цангадаг уу?” гэсэн асуултанд үгүй гэж 354 буюу 66.9 хувь, тийм гэж 72 буюу 12 хувь, заримдаа гэж 18.9 хувь нь хариулсан бол уяач нараас уралдаанч хүүхдийн хоол хүнс хувцас хэрэглэлийг хэн хариуцдаг талаар асуусан асуултанд 63 буюу 68.4 хувь нь уяач гэж, 26 буюу 28.2 хувь нь хурдан морины эзэн хэмээн хариулсан байна.

Уралдаанч хүүхдүүдээс “Уралдаан болон ажлын үед алдаа гаргавал морины эзэн/уяач хэрхэн ханддаг вэ?” гэсэн асуултанд 318 буюу 60.1 хувь нь яадаг ч үгүй, 157 буюу 29.6 хувь нь загнадаг, 24 буюу 4.5 хувь нь хаяа цохиж өшиглөдөг, 15 буюу 2.8 хувь нь морь унахыг хориглодог, 4 буюу 0.7 хувь нь хоол унд өгдөггүй хэмээн хариулсан байна.

Уралдаанч хүүхдүүд “Ер нь хавар уралдаан хийхгүй, зөвхөн зун уралддаг бол ямар вэ?” гэсэн асуултанд хавар уралдах гоё гэж 227 буюу 42.9 хувь, 299 буюу 56.5 хувь нь зөвхөн зун уралдаад, өвөл хавар хичээлдээ явж байвал зүгээр гэж хариулсан байна.

Хамгаалалтын хэрэгслээ уралдааны болон ажлын үед бүгдийг нь хэрэглэдэг гэж 278 буюу 52.5 хувь, уралдааны үед хэрэглээд бэлтгэл, сунгааны үед хэрэглэдэггүй хэмээн 47.5 хувь нь хариулсан байна.

Судалгаанд оролцсон хүүхдүүдийн 277 буюу 52.3 хувь нь ямар нэг байдлаар мориноосоо унаж байсан бөгөөд унах болсон шалтгаан нь 121 буюу 43.6 хувь нь замын хальтиргаанаас, 83 буюу 29.9 хувь нь үлий нүхэнд морь нь бүдэрсэн, 53 буюу 19.1 хувь нь морины болон тоос шороо их учир замаараа яваагүйгээс, 29 буюу 10.4 хувь нь олом жирэм, хазаар жолоо тасарсан гэсэн байна.

Эдгээр мориноосоо унасан гэсэн хариулт өгсөн хүүхдүүдийн 196 буюу 70.7 хувь нь ямар нэг байдлаар бэртэж гэмтсэн гэсэн хариултыг өгснөөс 51 буюу 26 хувь нь толгой өвдөх, тархи доргих, 55 буюу 28 хувь нь биеийн аль нэг хэсэг хөхрөх, шалбарч шархлах, 50 буюу 25.5 хувь нь хөл гараа гэмтээх, хугалах, 34 буюу 17.3 хувь нь хөл, гар нүүр хацраа хөлдөөх, 9 буюу 4.5 хувь нь нуруу, нугасаа гэмтээх гэсэн хариултыг тус тус өгсөн байх бөгөөд мориноос унах, бэртэж гэмтэх үедээ хамгаалалтын хувцасаа бүгдийг өмссөн байсан гэж 145 буюу 52.3 хувь, заримыг өмссөн байсан гэж 80 буюу 28.8 хувь, огт өмсөөгүй байсан гэж 52 буюу 18.7 хувь нь хариулсан байна.





Хурдан морины уралдаанч хүүхдүүд хамгаалалтын хувцасаа байнга бүгдийг өмсдөг гэж 44.9 хувь нь, каск байнга өмсдөг гэж 34 хувь нь, цээживч, хантааз өмсдөг гэж 15.8 хувь нь хариулсан байна.

Хаврын уралдааны үед болон уралдааны бэлтгэлийн үед хамгийн их бэртэл гэмтэл гардаг шалтгааныг дурьдана уу? гэсэн олон сонголттой асуултанд хамгийн олон сонгогдсон хариулт нь уралдааны зам гэж 158, дагаж байгаа машины тоос гэж 129, уралдааны үед хүүхдүүд бие биенийгээ гэмтээдэг гэж 106, бороо, цас, салхи, цаг агаар гэж 104 хүүхэд хариулсан байна.

Хаврын уралдааны үед болон уралдааны бэлтгэлийн үед бэртэж гэмтсэн даруй эмнэлгийн тусламж авч байсан уу? гэсэн асуултанд 44.8 хувь нь үгүй, 33.1 хувь нь заримдаа, 22.6 хувь нь тийм гэж хариулсан байх бөгөөд эмнэлгийн тусламж аваагүй шалтгааны 98 буюу 63.6 хувь нь ялимгүй гэмтэл байсан хэмээн хариулсан байна.

Мөн хүүхдүүдийн 71.6 хувь нь бэртэл гэмтэл хамгийн их гардаг улирлаар хаврын улирлыг, хурдан морь унах хамгийн сайхан улирлаар 88.8 хувь нь зуны улирал, хамгийн муухай, хэцүү улирлаар 81.6 хувь нь өвөл цастайд, 14.5 хувь нь хаврын улирлыг сонгож, хурдан морь унах хамгийн хэцүү нөхцлийг 223 буюу 42.1 хувь нь хальтиргаатай зам, 183 буюу 34.5 хувь нь уралдааны болон бэлтгэлийн үед цасаар шуурах гэсэн хариултыг сонгосон байна.

Эмч, эмнэлгийн ажилтан нараас авсан асуулгын судалгаагаар эмч нар уралдаанч хүүхэд хамгийн их бэртэж гэмтдэг сараар 6–8 сарыг нэрлэсэн бөгөөд энэ нь уралдааны тоо, хамрах хүрээнээсээ шалтгаалж байдаг гэсэн бол хаврын уралдаанд уралдаанч хүүхдүүд ихэвчлэн авдаг гэмтлээр судалгаанд оролцсон эмч нарын 10.2 хувь нь ясны хугаралт гэж, 10.2 хувь нь толгой тархины доргилт, 9.1 хувь нь хөлдөлт хайрагдалт авдаг хэмээн хариулсан байна.

Иргэдээс авсан асуулгын судалгаагаар хавар хүүхдээр хурдан морь унуулж байгаа нь хүүхдийн эрхийн зөрчил мөн гэж судалгаанд оролцсон иргэдийн 54 буюу 63.5 хувь нь, хүүхдийн эрхийн зөрчил биш гэж 31 буюу 36.4 хувь нь хариулсан бол морь унах тохиромжтой насаар 7–оос дээш гэж 30.5 хувь, 9–с дээш гэж 34.1 хувь нь хариулсан байна.

Харин хаврын хурдан морь уралдуулж байгааг зохимжгүй байна гэж 60 буюу 70.5 хувь, аюулгүй байдлыг нь сайн хангаад уралдуулахад болохгүй зүйл байхгүй гэж 25 буюу 29.4 хувь нь үзсэн байна.

УИМН
СУДАЛГААНЫ САН



Асуулгын судалгааны дүгнэлт

Дээрх судалгааг нэгтгэн дүгнэхэд гол төлөв эцэг, эхийн анхаарал халамж тааруу, амжиргааны түвшингөөс доогуур орлоготой гэр бүлийн хүүхэд хурдан морь унаж байгаа бөгөөд морь унаж олсон мөнгөө ар гэр, эцэг эхдээ өгч амжиргааг нь залгуулдаг байна.

Гэр бүл эцэг эхээсээ хол, айлд байж морь унаж, морины ажил хийдэг хүүхдүүдийн хувьд эцэг эх, гэр орноо санах, айлын аяыг харах, өлсөж цангах, даарч бээрэх, хүний үгээр байх, өвдөх, бэртэж гэмтэх зэрэг олон бэрхшээлийг туулж байгаа нь зан төлөв, хүмүүжил, сэтгэл зүйд нь хүндээр нөлөөлж байна.

Сургуульд сурдаг гэсэн бүртгэлтэй боловч нэр төдий бүртгэлтэй хүүхдүүд олон байдаг нь сургуулийн нийгмийн ажилтануудтай хийсэн ярилцлагаас тодорхой болж байлаа. Учир нь хурдан морь унах нэрээр зөвшөөрөлтэй, зөвшөөрөлгүй олон хоногоор хичээл тасалдаг, эргээд хичээлээ нөхөж авч чаддаггүй, сургууль багш нарын зүгээс хоцрогдол арилгах сургалт, давтлага өгөх боломж байхгүй, мөн хөдөө орон нутгаас хурдан морь унуулах зорилгоор зөвхөн хүүхдийг нь шилжүүлж сургуульд бүртгүүлээд хичээлд суулгалгүй морь унуулах, морины ажил хийлгэх зэрэг байдал ялангуяа төвийн аймгуудад ихээхэн гарах болсон ба энэ байдлыг эцэг эх нь мэддэг эсэх нь тодорхойгүй байгаа талаар ярьж байлаа.

Сургуулийн хувьд сурагчдыг улирааж, сургуулийн дүн, чанараас доош татахгүй байхын тулд сурлагын түвшингээр үеийн хүүхдүүдээс доогуур байгаа хүүхдүүдийг худал үнэлэн анги дэвшүүлэн сургаж байгаа нь нэг ангид суралцаж байгаа хүүхдүүдийн сурлагын түвшин эрс ялгаатай, бичиг үсгийн чадвар муу байгаа зэргээс ажиглагдаж байлаа.

Энэ нь эдгээр хүүхдүүдийн ирээдүйг хүнд хэцүү, харанхуй замруу түлхэн оруулж байгаагаас өөрцгүй байна. Учир нь ерөнхий боловсролын сургуулийг төгссөн нэр зүүх боловч цаашид сурч боловсрох, техникийн болон дээд боловсрол эзэмших мэдлэг, чадварыг эзэмшилгүйгээр амьдралд хөл тавьж байна.

Хурдан морь унадаг хүүхдүүд сургуулиас завсардсан гэх тоо энэхүү судалгаагаар бага гарсан боловч сургуульд бүртгэлгүй зөвхөн морь унаж, морины ажил хийж айлд амьдардаг хүүхдүүдийн тоог гаргах боломжгүй байна.

Судалгаанд оролцсон хүүхдүүд бэртэж гэмтсэн хэдий ч ялимгүй гэмтэл байсан хэмээн эмнэлгийн тусламж аваагүй хэмээн дийлэнх хувь нь хариулсан байгаагаас эмнэлгийн байгууллагад бүртгэлгүйгээр хүүхдийн эрүүл мэнд маш ихээр хохирч байгаа нь харагдаж байгаа юм. Өөрөөр хэлбэл эмнэлгийн байгууллагад бүртгэлтэй байгаа бэртэж гэмтсэн хүүхдүүдийн тоо нь эмнэлэгт хандахаас өөр аргагүй болсон хүнд тохиолдлуудын бүртгэл болж байна.





UIH.MN
СУДАЛГААНЫ САН





ХУРДАН МОРИНЫ ХАВРЫН УРАЛДААН БА ХҮҮХДИЙН ЭРХ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН





UIH.MN
СУДАЛГААНЫ САН